

**АГУУЛГА**

НЭГ. ОРШИЛ.....	6
1.1 Зөвлөх үйлчилгээний зорилго .....	6
1.2 Ажлын иж бүрдэл.....	6
1.3 Сумын танилцуулга, хөгжүүлэх үндсэн бодлого.....	9
1.4 Бүс нутгийн хөгжлийн чиг хандлага, бодлого .....	12
ХОЁР. ГАЗРЫН НӨӨЦ, АШИГЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ .....	14
2.1 Бэлчээрийн газрын экологийн чадавхийн үнэлгээ .....	14
2.2 Бэлчээрийн газрын эдийн засгийн үнэлгээ тооцох арга зүй.....	16
2.2.1 Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээ .....	16
2.2.2 Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох /Хонин сүрэг/ .....	17
2.2.3 Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох /Ямаан сүрэг/.....	20
ГУРАВ. СУМЫН ГАЗРЫН ТОХИРОМЖТОЙ БОЛОН ХЭРЭГЦЭЭТ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ.....	25
3.1 Сумын газрын тохиромжтой байдлын үнэлгээ .....	25
3.1.1 Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ .....	25
3.1.2 Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ .....	39
3.1.3 Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ .....	43
3.1.4 Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээ .....	44
3.1.5 Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ 48	
3.1.6 Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ .....	51
3.1.7 Усан сан, хөв цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээ .....	53
3.1.8 Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ.....	55
3.2 Орон нутгийн хэрэгцээт байдлын үнэлгээ .....	57
3.2.1 Малчин өрхийн хэрэгцээт байдлын үнэлгээ .....	58
3.2.2 Иргэн, хуулийн этгээдийн хэрэгцээт байдлын үнэлгээ .....	61
ДӨРӨВ. СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	62
4.1 Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө.....	62
4.2 Хамгаалалтын бүсийн төлөвлөгөө .....	64
4.2.1 Усны хамгаалалтын бүс .....	64
4.2.2 Ойн хамгаалалтын бүс .....	66
4.2.3 Зам шугам сүлжээний хамгаалалтын бүс .....	66
4.3 Хөдөө аж ахуйн газрын төлөвлөгөө.....	69
4.3.1 Бэлчээрийн газрын төлөвлөгөө .....	69
4.3.2 Бэлчээр усжуулалтын төлөвлөгөө.....	72
4.3.3 Бэлчээрийн ашиглалтын хэсгийн төлөвлөгөө .....	75
4.3.4 Хадлангийн газрын төлөвлөгөө.....	89
4.3.5 Тариалангийн газрын төлөвлөгөө.....	90

4.4	Зам шугам сүлжээний газрын төлөвлөгөө.....	92
4.4.1	Шинээр байгуулах хатуу хучилттай болон сайжруулсан авто замын газрын төлөвлөгөө .....	92
4.4.2	Засах зам гүүр, даваа, бартаатай авто замын газрын төлөвлөгөө.....	94
4.4.3	Шинээр байгуулах эрчим хүчний шугамын газрын төлөвлөгөө .....	96
4.5	Хот тосгон бусад суурин газрын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө.....	98
4.5.1	Сумын төвийн суурин газрын төлөвлөгөө .....	98
4.6	Тусгай хэрэгцээний газрын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө .....	102
4.6.1	Шинээр улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах газрын төлөвлөгөө 102	
4.6.2	Аялал жуулчлалын газрын төлөвлөгөө, маршрут .....	104
4.7	Зүй ёсны эрхээр ашиглах нутаг дэвсгэрийн төлөвлөгөө.....	106
	ДҮГНЭЛТ .....	109
	АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ .....	110

**Зургийн жагсаалт**

Зураг 1. Төсөлд хамрагдаж буй сумд .....	7
Зураг 2. Бэлчээрийн төлөв байдлын үнэлгээний зураг. ....	16
Зураг 3. Өвөл-Хаврын улиралд адуунд тохирох бэлчээрийн зураг .....	28
Зураг 4. Өвөл-Хаврын улиралд үхэрт тохирох бэлчээрийн зураг.....	29
Зураг 5. Өвөл-Хаврын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн зураг .....	30
Зураг 6. Өвөл-Хаврын улиралд хонинд тохирох бэлчээрийн зураг.....	31
Зураг 7. Өвөл-Хаврын улиралд ямаанд тохирох бэлчээрийн зураг .....	32
Зураг 8. Зун-Намрын улиралд адуунд тохирох бэлчээрийн зураг .....	35
Зураг 9. Зун-Намрын улиралд үхэрт тохирох бэлчээрийн зураг .....	36
Зураг 10. Зун-Намрын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн зураг .....	37
Зураг 11. Зун-Намрын улиралд хонинд тохирох бэлчээрийн зураг .....	38
Зураг 12. Зун-Намрын улиралд ямаанд тохирох бэлчээрийн зураг .....	39
Зураг 13. Тариалангийн тохиромжтой байдлын үнэлгээний зураг.....	42
Зураг 14. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг .....	44
Зураг 15. Аялал рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг.....	47
Зураг 16. Авто зам болон төмөр замын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг .....	49
Зураг 17. Цахилгаан дамжуулах агаарын шугамын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг.....	50
Зураг 18. Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг .....	52
Зураг 19. Хөв цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг .....	54
Зураг 20. Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг.....	56
Зураг 21. Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний зураг.....	63
Зураг 22. Хамгаалалтын бүсүүдийн төлөвлөгөөний зураг. ....	68
Зураг 23. Улирлын бэлчээр ашиглалтын зураг.....	71
Зураг 24. Усжуулах шаардлагатай бэлчээрийн төлөвлөгөөний зураг .....	73
Зураг 25. Хөв, цөөрөм байгуулах газрын төлөвлөгөөний зураг.....	74
Зураг 26. Бэлчээр ашиглалтын хэсгийн төлөвлөгөө зураг.....	79
Зураг 27. Бэлчээр ашиглалтын хэсгийн даацын зураг. ....	88
Зураг 28. Хадлангийн газрын төлөвлөгөөний зураг.....	89
Зураг 29. Тариалангийн газрын төлөвлөгөөний зураг .....	91
Зураг 30. Шинээр төлөвөж буй авто замын төлөвлөгөөний зураг.....	93
Зураг 31. Зам, гүүр засах газрын төлөвлөгөөний зураг .....	95
Зураг 32. Эрчим хүчний шугамын төлөвлөгөөний зураг .....	97
Зураг 33. Хот суурин газрын төлөвлөгөөний зураг .....	101
Зураг 34. Орон нутгийн тусгай хамгаалалтанд авах газрын төлөвлөгөө .....	103
Зураг 35. Аялал жуулчлалын төлөвлөгөөний зураг. ....	105
Зураг 36. Зүй ёсны эрхээр баталгаажуулах төлөвлөгөө.....	108

**Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1. Төсөлд хамрагдах аймаг сумын нэр, талбайн хэмжээ.....	8
Хүснэгт 2. Бэлчээрийн газрын төлөв байдлын үнэлгээ .....	14
Хүснэгт 3. Бэлчээрийн газрын жилийн нийт ургац .....	16
Хүснэгт 4. Малын бэлчээрээс өдөрт идэх өвсний хэмжээ улирал тус бүрээр.....	17
Хүснэгт 5 . Нядалгааны гарц тооцох.....	18
Хүснэгт 6. Монгол хонины махны гарц.....	18
Хүснэгт 7. Хонин сүргийн зохистой харьцаа .....	18
Хүснэгт 8. Хонины махны ашиг шим .....	19
Хүснэгт 9. Хонины сүү бий болгох чадавх.....	19
Хүснэгт 10. Хонины ноос бий болгох чадавх.....	19
Хүснэгт 11. Бэлчээрийн газрын бүтээгч чадавх .....	20
Хүснэгт 12. Нядалгааны гарц тооцох хүснэгт .....	21
Хүснэгт 13. Монгол ямааны махны гарц .....	21
Хүснэгт 14. Ямаан сүргийн зохистой харьцаа.....	21
Хүснэгт 15. Ямааны махны ашиг шим .....	22
Хүснэгт 16. Ямааны сүү бий болгох чадавх .....	23
Хүснэгт 17. Ямааны ноолуур бий болгох чадавх .....	23
Хүснэгт 18. Бэлчээрийн газрын бүтээгч чадавх .....	24
Хүснэгт 19. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га /Өвөл-Хавар/ .....	26
Хүснэгт 20. Таван хошуу малд тохиромжтой газрын хэмжээ, хувь /Өвөл-хавар/ .....	26
Хүснэгт 21. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га /Зун-Намар/ .....	32
Хүснэгт 22. Таван хошуу малд тохиромжтой газрын хэмжээ, хувь /Зун-намар/ .....	33
Хүснэгт 23. Тариаланд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га .....	41
Хүснэгт 24. Шинээр байгуулах хот, суурин газарт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га .....	43
Хүснэгт 25. Аялал жуулчлалын газарт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га .....	46
Хүснэгт 26. Авто замд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га.....	48
Хүснэгт 27. Шугам сүлжээд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га .....	48
Хүснэгт 28. Ой санд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га .....	51
Хүснэгт 29. Хадгалан хамгаалахад тохиромжтой газар .....	55
Хүснэгт 30. SWOT шинжилгээний үр дүн.....	57
Хүснэгт 31. Иргэдээс авсан саналын судалгаа/4 иргэний жишээн дээр/ .....	60
Хүснэгт 32. Сумын хамгаалалтын бүсүүдийн төлөвлөгөө .....	64
Хүснэгт 33. Усны хамгаалалтын бүсүүдийн талбай .....	65
Хүснэгт 34. Ойн хамгаалалтын бүсийн талбай .....	66
Хүснэгт 35. Шугам сүлжээний хамгаалалтын бүсийн талбай .....	67
Хүснэгт 36. Сумын улирлын бэлчээр ашиглалт, багаар.....	70
Хүснэгт 37. Бэлчээр усжуулалтын судалгаа .....	72
Хүснэгт 38. Хөв, цөөрөм байгуулах газрын төлөвлөгөө .....	73
Хүснэгт 39. Бэлчээр ашиглалтын хэсгийн талбай.....	75
Хүснэгт 40. Бэлчээр ашиглалтын хэсгийн багтаамж .....	79
Хүснэгт 41. Бэлчээр ашиглалтын хэсгийн даац .....	84
Хүснэгт 42. Хадлангийн газрын төлөвлөгөө .....	89
Хүснэгт 43. Төлөвлөж буй тариалангийн газрын талбайн хэмжээ.....	90
Хүснэгт 44. Шинээр төлөвлөсөн замын урт, км.....	92
Хүснэгт 45. Зам засах, гүүр барих газрын байршил .....	94
Хүснэгт 46. Эрчим хүчний шугам урт .....	96
Хүснэгт 47. Газар ашиглалтын бүсийн төлөвлөгөө .....	100
Хүснэгт 48. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрын төлөвлөгөөний газрууд .....	102
Хүснэгт 49. Аялал жуулчлалын маршрутын төлөвлөгөө .....	104

Хүснэгт 50. Аялал жуулчлал хөгжүүлэх газрын төлөвлөгөө ..... 104

### Графикийн жагсаалт

График 1. Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний схем.....	25
График 2. Таван хошуу малд тохиромжтой газрын хэмжээ, хувь .....	26
График 3. Таван хошуу малд тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь /Зун-намар/ .....	33
График 4. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд .....	40
График 5. Тариалангийн газрын тохиромжтой байдлын эзлэх хувь .....	41
График 6. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээний .....	43
График 7. Ландшафтын үнэлгээний схем .....	46
График 8. Аялал жуулчлалын газарт тохиромжтой газрын эзлэх хувь.....	46
График 9. Шугаман байгууламжийн тохиромжтой байдлын үнэлгээ.....	48
График 10. Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээ.....	51
График 11. Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний үндсэн чиг хандага .....	62
График 12. Улирлын бэлчээрийн эзлэх хувь .....	70
График 13. Бэлчээр усжуулалтын хувь .....	72

## НЭГ. ОРШИЛ

Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам, Нэгдсэн Үндэсний Байгууллага-Хөгжлийн Хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж байгаа “Монгол орны баруун бүсэд газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх нь” (МОН 16/301-Т05) төслийн хүрээнд “Газрын нэгдсэн мэдээллийн сан байгуулах, газар ашиглалтын төлөвлөгөөг аймгийн болон сумын түвшинд боловсронгуй болгох” зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэхээр 2016 оны 10 сард “Вектор Мэп” ХХК гэрээ байгуулан ажиллаж хийж гүйцэтгээд байна.

### 1.1 Зөвлөх үйлчилгээний зорилго


Төсөл хэрэгжих буй Увс аймгийн Бөхмөрөн сум, Завхан аймгийн Дөрвөлжин сум, Ховд аймгийн Дарив сумын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын гадаргуу, газар ашиглалт, хүрээлэн буй орчин, инженер геологи, нийгэм, эдийн засгийн мэдээллийн сан байгуулах, газар болон байгалийн нөөц нөхцлийг зүй зохистой ашиглах боломж, газрын тохиромжтой байдлын үнэлгээн дээр суурилсан, нутаг дэвсгэрийн цаашдын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад чиглэсэн ажил болно.

### 1.2 Ажлын иж бүрдэл

“Газрын нэгдсэн мэдээллийн сан байгуулах, газар ашиглалтын төлөвлөгөөг аймгийн болон сумын түвшинд боловсронгуй болгох” зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлыг 3 аймгийн 3 сумын газар нутгийг бүрэн хамруулж дараах иж бүрдэлтэйгээр хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Хамрагдах 3 сумын дараах тоон болон статистик мэдээг бүрдүүлэн ажиллана. Үүнд:
  - Байр зүйн мэдээ
  - Агаар сансрын зургийн мэдээ
  - Засаг захиргааны хилийн мэдээ
  - Уур амьсгалын мэдээ
  - Газрын гадаргын мэдээ
  - Байгалийн нөөц, дагалдах баялгийн мэдээ
  - Ургамалжилтын мэдээ
  - Хөрсний мэдээ
  - Ойн мэдээ
  - Инженер геологи, гидрологийн мэдээ
  - Газар ашиглалтын мэдээ
  - Нийгэм эдийн засгийн мэдээ

2. Мэдээлэл дүн шинжилгээ хийж мэдээллийн сан үүсгэн, зохих боловсруулалтыг хийлээ.
  - Бэлтгэсэн тоон болон шинж чанарын мэдээлэлд тулгуурлан тухайн сумын нутаг дэвсгэрийн газар, байгалийн нөөц, газрын төлөв байдал, чанарт анализ дүн шинжилгээний тоон боловсруулалтыг хийж зурган мэдээг төрлөөр /ГНС, ашиглалтын байдал, хүрээлэн буй орчин г.м/ ангилж гаргах ба зохих дүгнэлт зөвлөмжийг гаргана.
  - ГЗБГЗЗГ-ын холбогдох хэлтэсүүдтэй хамтран ажиллаж тоон мэдээлэлдээ тулгуурлан ашиглалт бүрээр тохиромжтой байдлын үнэлгээний арга зүйн дагуу тохиромжтой байдлын үнэлгээ хийж нийгэм эдийн засаг, статистикийн мэдээг боловсруулж хэрэгцээт байдлыг урьдчилсан байдлаар тодорхойлж мэдээллийн сан үүсгэнэ.
  - Хээрийн хэмжилт судалгааг холбогдох мэргэжилтэн, орон нутагтай хамтран гүйцэтгэж газар ашиглалтын тохиромжтой байдал, одоогийн ашиглалтыг газар дээр тодруулж зохих хэмжилт, өөрчлөлтүүдийг хийж иргэд, хуулийн этгээдээс санал болон хэлэлцүүлэг хийнэ.
  - Бэлтгэл болон хээрийн судалгааны ажлын үр дүнг боловсруулж мэдээллийн санг шинэчлэн сайжруулж улмаар газар ашиглалтын тохиромжтой болон хэрэгцээт байдлыг нарийвчлан тодорхойлж нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж гаргана.
  - Мөн зүй ёсны эрхийн зориулалтаар газар ашиглах боломжтой нөөцийн байршил, хэмжээг тогтоож, зурагт буулган төлөвлөлтөд тусгана.
3. Хамрах хүрээ. Увс аймгийн Бөхмөрөн сум, Завхан аймгийн Дөрвөлжин сум, Ховд аймгийн Дарви сумын нийт 1 658 717.43 га газар нутгийг хамарна.



Зураг 1. Төсөлд хамрагдаж буй сумд

## Хүснэгт 1. Төсөлд хамрагдах аймаг сумын нэр, талбайн хэмжээ

Д/д	Аймаг	Сум	Талбайн хэмжээ /га/	Хамрагдах байдал
1	Увс	Бөхмөрөн	383177.33	Мэдээллийн сан үүсгэх, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах
2	Ховд	Дарви	554512.65	Мэдээллийн сан үүсгэх, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах
3	Завхан	Дөрвөлжин	721026.09	Мэдээллийн сан үүсгэх, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах

4. Газар байгалийн нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх, тэдгээрт дүн шинжилгээ хийхэд дараах журам зааврыг баримтлана. Үүнд:

- Монгол улсын хууль, эрх зүйн орчинд нийцсэн байх;
- ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/200 тоот тушаалаар батлагдсан Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээний арга зүй;
- ГХГЗЗГ-ын даргын 2011 оны А/497 тоот тушаалаар батлагдсан Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал;
- ГХГЗЗГ-ын даргын 2013 оны А/140 тоот тушаалаар батлагдсан Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний зурган мэдээлэл боловсруулах заавар;
- ГХГЗЗГ-ын даргын 2007 оны А/281 тоот тушаалаар батлагдсан хөрсний зургийг тоон хэлбэрт хөрвүүлэх заавар;
- Засгийн газрын 2003 оны 28-р тогтоолоор батлагдсан “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам” болон холбогдох зааврууд;
- Төлөвлөлтийн зургийг Монгол улсын стандарт “Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 1:500000, 1:2000, 1:5000 масштабын зургийн таних тэмдэг” MNS 6316:2012 мөрдөх,
- “Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний 1:1000, 1:100000 масштабын зургийн таних тэмдэг” MNS 6315:2012 болон атрибут мэдээллийн тоон өгөгдлийн стандарт дагуу бүрдүүлэх.
- ArcGIS, Erdas imagine, Mapinfo, Quantum GIS, Land manager зэрэг программ хангамж дээр суурилсан боловсруулалт, дүн шинжилгээ хийх ба холбогдох стандарт, зааврын дагуу Geodatabase бүрдүүлж ажиллах.



- Засгийн газрын 2009 оны 25-р тогтоолоор батлагдсан WGS-84 солбицол, өндрийн сүлжээг Балтийн тэнгисийн өндрийн тогтолцоонд байгуулж, тоон мэдээний боловсруулалт зураглалыг UTM тусгалгаар хийх.

Тус ажлыг дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

- Бэлтгэл үе шат,
- Хээрийн хэмжилт, судалгаа
- Материал боловсруулалт
- Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж дуусгах
- Сургалт зохион байгуулах, дадлагажуулах
- Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж албажуулж баталгаажуулах
- Тайлан, зураг хүлээлгэн өгөх

Дээрх үе шатны ажлууд хийгдэж дууссан дараа сум тус бүрээр газар байгалийн нөөцийн мэдээллийн сан үүсгэж нэгтгэн, зохих мэдээллээр сэдэвчилсэн зургууд, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний тайланг боловсруулж цаасан болон тоон хэлбэрээр ГЗБГЗЗГ-ын мэдээллийн төв, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нэгдсэн Үндэстэний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр хамтран хэрэгжүүлж буй “Монгол орны баруун бүсэд газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх нь” төсөл, орон нутагт тус тус хүлээлгэж өгнө.

### **1.3 Сумын танилцуулга, хөгжүүлэх үндсэн бодлого**



Засагт хан аймгийн Эрдэнэбэйсийн хошууг 1921 онд Хантайшир аймгийн Сутай уулын хошуу хэмээн нэрлэснээр Ховд аймгийн Дарви сум байгуулагдсан түүхтэй. Дарви сум нь дэд бүтцийн хувьд харьцангуй давуу талтай, үүнд Ховд болон Алтай хотуудтай, мөн БНХАУ руу гарах Ярантын хилийн боомттой (400 км) тус тус хар замаар холбогдсон, суманд үүрэн холбооны бүх операторууд үйл ажиллагаа явуулдаг, Баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон. Иймд экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх, Улаанбаатар хот ба Ховд аймгийн бусад сумд, Баян-Өлгий аймагтай холбогдох гол зам дагуу байрлалтай тул үйлчилгээний салбарыг мөн хөгжүүлэх бүрэн боломжтой.

Нутаг дэвсгэрийн нийт хэмжээ 554.512 мянган га.бөгөөд газар нутгийнхаа хэмжээгээр аймагтаа Алтай, Булган, Үенч сумдын дараа ордог.

Тус сумын эдийн засгийн тулгуур салбар нь мал аж ахуй бөгөөд нийт малынхаа тоогоор аймагтаа 4-р, хонины тоогоор тэргүүн байранд ордог. Мал бүхий нэг өрхөд ногдох малын тоогоор улсын болон аймгийн дунджаас 100 орчим толгойгоор илүү байна. Үүнээс

үзэхэд мал аж ахуй, түүний дотор хонин сүрэг, газар тариаланг хослуулан хөгжүүлэх боломж байгаа юм.

Дарви сумын эдийн засгийн тулгуур салбарын нэг нь уул уурхай юм. Тус суманд Хөшөөтийн нүүрсний орд газар байхаас гадна мөнгө, зэс, өнгөт чулуу, төрөл бүрийн шороон будаг, чулуужсан модны ордтой. Сумын төвөөс 50 км-т орших Хөшөөтийн нүүрсний ордыг түшиглэн 1972 онд нүүрсний уурхай байгуулсан бөгөөд энэ ордны нүүрсний нөөцийг 1980 оны эхний байдлаар дээд үе буюу В, Ц, давхрагаар өмнөд ба төв хэсэгт 24 сая тонн, геологийн төсөөллийн нөөц Р2 зэргээр 197 сая тонн нүүрстэй гэж тооцжээ. Ордны нүүрсний чанар сайн, ашигт үе нь зузаан, ашиглалтын уул геологийн болон гидрогеологийн нөхцөл сайн, газрын доорхи усны түвшин доогуур байгаа нь нүүрсийг ил аргаар гаргаж ашиглах боломжтойг харуулна. Өнөөдрийн байдлаар Мо Эн Ко компани ашиглаж байна. Хөшөөтийн нүүрсний орд нь Ховд аймгийн төв болон Ховд, Говь-Алтай аймгийн 10 гаруй сумыг нүүрсээр хангахын зэрэгцээ БНХАУ руу экспортод гаргаж байна. Хөшөөтийн уурхайд тус сумын 40 гаруй өрхийн 110 хүн гэрээгээр ажиллаж байгаа. Хөшөөтийн уурхайгаас өөр томоохон аж ахуйн нэгж тус суманд үйл ажиллагаа явуулдаггүй байна.

Дарви сумын нутаг дэвсгэрт төрийн тахилгат Сутай (4090 м), мөн Бумбат хайрхан (3750 м), Дарвийн нуруу (2686 м) зэрэг өндөр ба дундаж өндөрлөг уулстай бөгөөд говь хээр, уулын хээр, ойт хээр хосолсон байгалийн өвөрмөц төрхийг хадгалсан үзэсгэлэнт байгальтай. Мөнх цаст Сутайгаас эх авсан болон түүний салбар салаа бүрээс урссан олон рашаан, гол горхи, булаг шандтай, үүний нэг нь 108 ундрагатай рашаан юм. Үүнээс гадна Ази тивд байдаг 3 том хиргисүүрийн нэг Загал баатарын хиргисүүр байдаг ба хадны бичээс, сүг зураг зэрэг түүх дурсгалын газруудтай. Үүнээс үзэхэд Дарви сум нь аялал жуулчлалын нөөц сайтай сумдын тоонд зүй ёсоор орох юм.

Сум хөгжүүлэх үндсэн баримт бичгийг Ховд аймгийн Дарви сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 4-р сарын 22-ний өдрийн 4-р хуралдааны 04 дугаар тогтоолоор батлагдсан “Сумын хөгжлийн цогцолбор төлөвлөгөө (2013-2023) ” -д нийцүүлэн тусгалаа.

*Сумын хөгжлийн зарчим алсын хараа, тэргүүлэх чиглэлүүд:*

**Алсын хараа:**

Олон алдартнуудыг төрүүлсэн оюунлаг Дарвичууд бид эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг иргэдтэй, мал аж ахуй газар тариалан хосолсон байгаль орчинд ээлтэй баруун бүсийн хэвтээ тэнхлэгийн агуух “Жижиг сум” болох зорилт тавин ажиллана.

**Дарви сумын тэргүүлэх чиглэлүүд**

Сумын нийгмийн хөгжил: Өрх бүр ажилтай орлоготой болж, ажилгүйдэл, ядуурлын түвшин жилээс жилд бууруулж 5 хувиас хэтрүүлэхгүй байх;

Нутгийн зан заншил өв уламжлалыг сэргээн хадгалж амьдралд хэвшүүлэн, өрх бүр ургийн бичиг хөтөлдөг болсон байна.

Иргэн бүр эрүүл мэндийн боловсролтой мэдээлэл технологийн дэвшилд хүрч ашиглаж чаддаг болсон байна.

Эдийн засгийн тэргүүлэх чиглэл: Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж өрх бүр үйлдвэрлэгч байж ажлын байрыг нэмэгдүүлэх;

Орон нутгийн байгалийн баялгийг ашиглаж эдийн засгийн эргэлтэнд оруулах

Орон нутгийн байгалийн үзэсгэлэнт үзэсгэлэнт газраа түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх

Хөдөө аж ахуйн тэргүүлэх чиглэл: Малын удмын санг бэхжүүлэх замаар Сутай омгийн малыг үүлдэрийг хэсэг болгоно.

Мал аж ахуй түүхий эдийг биржээр /мах ноос ноолуур арьс шир, яс, өлөн дайвар бүтээгдэхүүн/ худалдан борлуулах эрхтэй бирж байгуулна.

Малчдын санаачлагад тулгуурлан малчдын бүлэг, хоршоо, фермерийн аж ахуйг хөгжүүлж бэхжүүлнэ.

Усалгаатай тариалангийн га-гаас авах ургац, талбайн хэмжээг 2 дахин нэмэгдүүлнэ.

Байгалийн нөөц, байгаль орчныг хамгаалах тэргүүлэх чиглэл: Иргэдийн оролцоотойгоор байгаль орчинд ээлтэй, нөөц баялагт суурилсан, орон нутгийн онцлогт тохирсон байгаль орчин, уул уурхайн бодлого боловсруулах

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэвтэй чиглэлийн засмал замтай уялдуулан төлөвлөх, сум дундын төв суурин газрын төлөвлөгөө рүү ойртуулах

Бэлчээр ашиглалтын талаар бодлого боловсруулж эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлэх;

**Тэргүүлэх чиглэлийн хүрээнд тавьж буй зорилтууд:**

Нийгмийн хөгжлийн зорилтууд: Өрх бүр ажилтай орлоготой болж, ажилгүйдэл, ядуурлын түвшинг жилээс жилд бууруулж 5 хувиас хэтрүүлэхгүй байх;

Амьдрах ухааны сургалтанд иргэдийг үе шаттайгаар хамруулах;

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд элсэх сурагчдын тоог нэмэгдүүлэх төгсөгчдийг орон нутагтаа ажиллах боломжийг бий болгоно.

Сум хөгжүүлэх сангийн зээлийг үргэлжлүүлэн олгож ажлын байрыг нэмэгдүүлэх;

Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж залуу малчдыг дэмжих;

Жижиг дунд үйлдвэрлэл болон уурхайд ажиллах иргэдийг чавдаржуулах;

Халамжийн хавтгайрсан үйлчилгээг багасгаж иргэдийг өөр орлогын эх үүсвэртэй болгоход дэмжин ажиллах;

Нутгийн зан заншил өв уламжлалыг сэргээн хадгалж амьдралд хэвшүүэн өрх бүр ургийн бичиг хөтөлдөг болсон байна.

Ургийн бичгийг хөтлөхөд холбогдох мэдээлэл гарын авлагаар хангах;

Айл өрх бүр Ургийн баярыг тэмдэглэдэг болох;

Соёлын өв тээгч ахмад настныг түшиглэн залуу хойч үедээ өвлүүлж үлдээх;

Уламжлалт зан заншлыг харуулсан тэмцээн уралдааныг үе шаттайгаар зохион байгуулах;

Уламжлалт соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэн хөгжүүлэх ажлыг зохион байгуулах;

Иргэн бүр эрүүл мэндийн боловсролтой эрүүл Эко орчин бүрдсэн байна.

Эмийн бус ардын уламжлалт эмчилгээг дэлгэрүүлэх;

Багийн эмч нарыг чадавхжуулж эмгүй эмчилгээний сургалтуудыг зохион байгуулна.

#### **1.4 Бүс нутгийн хөгжлийн чиг хандлага, бодлого**

Монгол улсын Мянганы Хөгжлийн Зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, аймгийн хөгжлийн бодлого болон засаг даргын /2016-2020 /мөрийн хөтөлбөрийг бодлогын чиг хандлага болгон сум хөгжлийн төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулав.

Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилго, зорилт болон хөтөлбөрт тусгагдсан аймгийн эдийн засгийн бодлогын баримт бичгийн хүрээнд дараах асуудлыг тусгасныг сумын хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэл болгож байна.

Үүнд: Эдийн засгийн хүрээнд:

Зорилго-1. Төрийн үндсэн чиг үүргийг чанар, хүртээмжтэй хэрэгжүүлэх

1.1. Эдийн засгийн бодлого зохицуулалтыг сайжруулах

1.2. Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх

1.3. Төрийн захиргааны удирдлага, зохицуулалтыг чанаржуулах

1.4. Эрх зүйн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

Зорилго-2. Үйлчилгээний менежментийг дээшлүүлэн хүний хөгжлийг эрхэмлэн үйлчилгээний таатай орчинг бүрдүүлэх

2.1. Төр, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн бизнесийн түншлэлийг сайжруулж, үйлчилгээг ил тод цогцоор хүргэх

2.2. Өөрчлөлтийг мэдэрч хөгжих чадвартай, нийгмийн баталгаагаар хангагдсан жендерийн мэдрэмжтэй чадварлаг баг бүрдүүлэх

2.3. Үйлчилгээний эрүүл, тохилог, хүртээмжтэй орчинг бүрдүүлэх

Тогтвортой эдийн засагтай, тэргүүлэх аймаг болно.

3.1 Малын үүлдэр угсааг сайжруулах, тоо толгойг зөв зохистой өсгөх шинэ технологийг нэвтрүүлнэ.

3.1.1 Мал тоо, сүргийн бүтцийн зохистой харьцааг баримталж уур амьсгалын өөрчлөлтөнд засан зохицох эрсдэл даах чадвартай малын тоог нэмэгдүүлнэ

3.1.2 Бэлчээрийн болон хагас эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж сумдад үхэр болон үхэр хонины аж ахуйг түлхүү хөгжүүлэх бодлого баримтална.

3.1.3 Бэлчээрийн усан хангамжийг жил бүр нэмэгдүүлнэ

3.1.4 Хоршоо Фермерийн аж ахуйг хөгжүүлж хүн амын хүнсний хэрэгцээг дотоодын үйлвэрлэлээр бүрэн хангах зорилт тавьж ажиллана.

3.1.9 Бэлчээрийн төлөв байдал, доройтол үнэлгээг олон улсын аргачлалаар хийж менежментийн төлөвлөгөө боловсруулан бэлчээрийн зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.1.10 Нийт бэлчээрийн 20иос доошгүй хувийг сум дундын отрын бүс нутаг, нөөц бэлчээр болгох шийдвэрийг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар гаргуулна.

3.1.11 Хадлангийн талбайг зөв зохистой ашиглах бодлого боловсруулж хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих замаар хадлан бэлтгэлийг нэмэгдүүлж дотоодын хэрэгцээг бүрэн хангаж гадаадад экспортолно.

Дээрх зорилго зорилттой нийцүүлэн Дарви сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг хийлээ.

**ХОЁР. ГАЗРЫН НӨӨЦ, АШИГЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ****2.1 Бэлчээрийн газрын экологийн чадавхийн үнэлгээ**

Ховд аймгийн Дарив сумын бэлчээрийн газрын төлөв байдлыг ангилахдаа ГХБГЗЗГ-ын даргын 2009 онд батлагдсан “Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг гүйцэтгэх, үр дүнг хүлээн авах журам”-ын дагуу хийж гүйцэтгэсэн.

Тус суманд өндөр уулын бэлчээрийн уулын царамын хүлрэнцэр ялзмагт, өндөр уулын нугын хар шороорхуу хөрстэй бэлчээр 50.4 мян.га, дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээрийн уулын сул хөгжилтэй хар хүрэн ба хар шороон хөрстэй нугархаг хээрийн сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээр 34.0 мян.га, уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хуурай хээрийн бэлчээр 55.2 мян.га, уулын цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээрийн бэлчээр 112.5 мян.га, уулсын хоорондох хөндийн цэвдэгт нугат намгийн ялзмагт хөрстэй өндөр уулын нугын бэлчээр 1.7 мян.га, нам бэсрэг уулсын хоорондох нугын хөндийн бэлчээрийн уулсын хоорондох хөндийн гүндээ цэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нугын бэлчээр 79.8 га, тал хээрийн бэлчээрийн тэгшивтэр хөндийн элсэнцэр хүрэн хөрстэй хээрийн бэлчээр 23.4 мян.га, довцог бөөрөг элсний сул бэхэжсэн хөрстэй хуурай хээрийн бэлчээр 3.3 мян.га, цөлөрхөг хээрийн бэлчээрийн гүвээрхэг болон тэгшивтэр хөндийн цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээр 243.0 мян.га, говь цөлийн бэлчээрийн тэгшивтэр хөндийн бор, бор саарал хөрстэй говийн бэлчээр 1.8 мян.га талбайг тус тус эзэлж байна.

*Хүснэгт 2. Бэлчээрийн газрын төлөв байдлын үнэлгээ*

№	Бэлчээрийн төрөл төрөл	Талбай, га	Эзлэх хувь
<b>Өндөр уулын бэлчээр</b>			
1	Уулын царамын хүлрэнцэр ялзмагт, өндөр уулын нугын хар шороорхуу хөрстэй өндөр уулын нуга	50447.2	9.1
<b>Дундаж өндөр болон нам. бэсрэг уулын бэлчээр</b>			
2	Уулын сул хөгжилтэй хар хүрэн ба хар шороон хөрстэй нугархаг хээрийн сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээр	33952.1	6.1
3	Уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хуурай хээрийн бэлчээр	55161.4	9.9
4	Уулын цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээр	112506.2	20.3
<b>Өндөр уулын хоорондох нуга хөндийн бэлчээр</b>			
5	Уулсын хоорондох хөндийн цэвдэгт нугат намгийн ялзмагт хөрстэй өндөр уулын нуга	1747.7	0.3
<b>Нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндий</b>			
6	Уулсын хоорондох хөндийн гүндээ цэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нуга	79.8	0.0
<b>Тал хээрийн бэлчээр</b>			
7	Тэгшивтэр хөндийн элсэнцэр хүрэн хөрстэй хээрийн бэлчээр	23391.6	4.2
8	Довцог бөөрөг элсний сул бэхэжсэн хөрст хуурай хээр	3289.5	0.6
<b>Цөлөрхөг хээрийн бэлчээр</b>			
9	Гүвээрхэг болон тэгшивтэр хөндийн цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээр	243042	43.8

<b>Говь цөлийн бэлчээр</b>			
10	Тэгшивтэр хөндийн бор, бор саарал хөрстэй говийн бэлчээр	1790.6	0.3
<b>Бэлчээрт тохиромжгүй</b>			
11	Дэрс	27356.6	4.9
12	Нуур	322	0.1
13	Элс	1425.7	0.3
Нийт		554512.4	100

Өндөр уулын бэлчээрийн уулын царамын хүлрэнцэр ялзмагт, өндөр уулын нугын хар шороорхуу хөрстэй өндөр уулын нугын бэлчээрт бушилж-улалжит, улалж-бушилзат, бушилзат бүлгэмдэл тархана.


Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээрийн уулын сул хөгжилтэй хар хүрэн ба хар шороон хөрстэй нугархаг хээрийн сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээрт жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст ургамлын бүлгэмдэл зонхилон тархана. Уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хуурай хээрийн бэлчээрт хялгана-хазаар өвст бүлгэмдэл зонхилон тархана. Мөн тус бэлчээрт хялганат, хялгана-алаг өвст, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст ургамлын бүлгэмдэлүүд хам байдлаар тархана. Уулын цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээрийн бэлчээрт монгол өвс-хазаар өвст, хазаар өвс-монгол өвст, монгол өвс-таанат, монгол өвс-шавагт, монгол өвс-баглуурт ургамлын бүлгэмдэлүүд хам байдлар тархана.

Өндөр уулын хоорондох нугын хөндийн бэлчээрийн уулсын хоорондох хөндийн цэвдэгт нугат намгийн ялзмагт хөрстэй өндөр уулын нугын бэлчээр жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст-бушилзат ургамлын бүлгэмдэл тархана.

Нам бэсрэг уулсын хоорондох нуга хөндий бэлчээрийн уулсын хоорондох хөндийн гүндээ цэвдэгтэй хар шороон ба хар хүрэн хөрстэй уулын нугын бэлчээрт жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст хээржсэн нугын ургамлын бүлгэмдэл тархана.

Тал хээрийн бэлчээрийн тэгшивтэр хөндийн элсэнцэр хүрэн хөрстэй хээрийн бэлчээрт хялгана-харганат, довцог бөөрөг элсний сул бэхэжсэн хөрст хуурай хээрийн бэлчээрт сөөг-үетэнт ургамлын бүлгэмдлүүд голлон тархана.

Цөлөрхөг хээрийн бэлчээрийн гүвээрхэг болон тэгшивтэр хөндийн цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээрийн бэлчээрт баглуур-монгол өвст, бор бударгана-таана-баглуурт, бударгана-монгол өвс-таанат ургамлын бүлгэмдэл тархана



Зураг 2. Бэлчээрийн төлөв байдлын үнэлгээний зураг.

**2.2 Бэлчээрийн газрын эдийн засгийн үнэлгээ тооцох арга зүй**

Бэлчээрийн газрын суурь үнэлгээг тооцохын тулд дараах 3 байдлаар үнэлж тооцлоо. Үүнд:

1. Хөрсийн чанарын үнэлгээ /Хчү/
2. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээ /БГбчү/
3. МАА үйлдвэрлэлийн бизнес тооцооллын аргаар үнэлсэн үнэлгээ /Окү/

Дээрх 3 үнэлгээгээр бэлчээрийн газрын суурь үнэлгээ /Гсү/ гарах юм.

$$Гсү = Хчү + БГбчү + МААб$$

**2.2.1 Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээ**

Бэлчээрийн газрын жилийн нийт ургац (в)-ыг дараах хүснэгтээр тооцно.

Хүснэгт 3. Бэлчээрийн газрын жилийн нийт ургац

Багийн нэр	Бэлчээрийн талбай /га/	1 га-гийн ургац /цн/	Нийт ургац /цн/
Баянбулаг баг	110002.607	1.902105	209236.5
Дэлгэр баг	151791.867	1.923214	291928.3
Мөрөн баг	152019.965	1.95775	297617.1
Мөнгөн-Аяга баг	99045	1.930741	191230.2
<b>Нийт</b>	<b>512859.439</b>		<b>990012.1</b>



## Хүснэгт 4. Малын бэлчээрээс өдөрт идэх өвсний хэмжээ улирал тус бүрээр

Малын төрөл	Улирал ба өвсний хэмжээ /кг/			
	Зун	Намар	Өвөл	Хавар
Адуу	7.8	8.1	6.5	5.8
Тэмээ	14.1	13	8.4	9.9
Үхэр	8.7	9.7	7.4	7.4
Хонь	1.9	1.6	1.1	1.1
Ямаа	1.3	1.4	1	1

Бэлчээрийн газрын нийт ургацыг мал жилийн 4 улиралд идэх бөгөөд ургац зун ногоон, намар хагдарч эхлэх, өвөл, хавар хагд байдлаар мал идэгддэг билээ. Тиймээс нэг хонин толгойн жилд идэх ургацыг дараах байдлаар тооцно.

$$a1 = \frac{H \cdot HM_z}{100}, \quad a2 = \frac{H \cdot HM_n}{100}, \quad a3 = \frac{H \cdot HM_{ox}}{100},$$

a1-нэг хонин толгойд идэгдэх ургац /Зун/

a2-нэг хонин толгойд идэгдэх ургац /Намар/

a3-нэг хонин толгойд идэгдэх ургац /Өвөл, хавар/

H-ногоон масстай байх хоногийн тоо

HM- нэг өдөр идэх ургац

$$a1 = \frac{90 \cdot 1.9}{100} = 1.71 \text{ тн}, \quad a2 = \frac{45 \cdot 1.6}{100} = 0.504 \text{ тн}, \quad a3 = \frac{230 \cdot 1.1}{100} = 1.265 \text{ тн},$$

$$x1 = \frac{v \cdot a1^2}{a1^2 + a1 \cdot a3 - a1 \cdot a2} = \frac{990012.1 \cdot 2.9241}{2.9241 + 2.16315 + 0.86184} = \frac{611828.475}{5.94909} = 102844.04$$

Эндээс малд идэгдэх бодит ургац 102844.04 цн

Бэлчээрийн багтаамжийг тооцоходоо малд идэгдэх бодит ургацыг нэг хонин толгойн өдөрт идэх ургацад /1,1/ харьцуулж үзэхэд 93494 хонин толгой болж байна.

### 2.2.2 Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох /Хонин сүрэг/

Монголчууд эрт дээр үеэс өсгөн үржүүлж ирсэн таван хошуу малын нэг бол хонин сүрэг Төв Азийн цаг уурын нөхцөлд бэлчээрээр маллахад зохиолдсон, биологи аж ахуйн өвөрмөц онцлогтой, ялангуяа говь, цөлөрхөг хээр, уулархаг нутгийн бэлчээр чадамгай ашиглаж, хөнгөн, хүнсний үйлдвэрийн чухал түүхий эд бүтээдэг аж ахуй билээ. Ховд аймгийн Дарви суманд Сутай омгийн хонины цөм сүрэг байдаг. Сутай омгийн хонь нь ашиг шимээр өндөр билээ. Сутай уулсын өвөрмөц байгаль экологийн нөхцөл, мал маллагаанд зохицсон. Чийрэг бие цогцостой, тэсвэртэй, гялбирын элдэв согоггүй, Сэрвээ намхан, ууц махлаг, өргөн хөдөлгөөн хурдан, махлаг шинж сайн хөгжсөн, богино өөхөн сүүлтэй. Хонины махны ашиг шимийг бий болгох боломжийг дараах томъёогоор бодож гаргана.

$$Mm = \frac{\left[ \frac{AJm}{100} + (AJ\partial - AJm) \right] HГm}{100}$$

Мт-Тухайн насны малын махны жилийн өсөлт буюу үйлдвэрлэгдэж буй  
махны хэмжээ

АЖд-Дараах насны малын амьдын жин

АЖт-Тухайн насны малын амьдын жин

НГ-Тооцож буй малын нядалгааны гарц

*Хүснэгт 5. Нядалгааны гарц тооцох*

Д/д	Малын төрөл	Нядалгааны гарц хувиар
1	Үхэр	55-65
2	Хонь, ямаа	44-48
3	Адуу	47-54
4	Тэмээ	55-65

*Хүснэгт 6. Монгол хонины махны гарц*

Насны ялгаа	Амьдын жин /кг/	Гулуузын жин /кг/	Гарц /%/
12 сартай	28.9	10.2	42.5
1.5 настай	43.78	21.1	48.1
2.5 настай	51	26.9	52.7
3.5 настай	58.3	32.2	55.3
4.5 настай	60.5	33.5	55.3
5.5 настай	70.9	38.8	54.6

Дарвийн Сутай омгийн хонины үржлийн хуцны дундаж амьдын жин 60-65 кг, төлгөн хуцных 45 кг, эм хониных 55кг, охин төлөгнийх 41 кг байдаг байна.

*Хүснэгт 7. Хонин сүргийн зохистой харьцаа*

Д/д	Нас	Сүрэгт эзлэх хувь	Бүгд
1	1.5	48.7	69230
2	2.5	50.8	72171
3	Хээлтүүдэгч	0.5	765

Хонины махны ашиг шимийг бий болгох боломжийг тооцож гаргавал дараах байдалтай байна.

## Хүснэгт 8. Хонины махны ашиг шим

Нас, хүйс	Амьдын жин	Зун-намрын улиралд нэмэгдэх /нэг хонин толгойд/				Малын тоо	Бүгд нэмэгдэх
		Өвөл-хавар алдсан жин /кг/	Нас дэвших хүртлэх нэмэгдэх жин	Бүгд нэмэгдэх	Бүгд нэмэгдэл нядалгааны гарцаар		
1.5	43.8	13.1	7.2	20.3	9.7	69230	671531
2.5	51	15.3	7.3	22.6	10.8	72171	779446.8
3.5	58.3	17.5	2.2	19.7	9.5		0
Хээлтүүлэгч	57	17.1	14	31.1	14.9	765	11398.5
Бүгд						142166	1462376.3

Дээрх хүснэгтээр тооцсон хонины махыг хонин толгойд шилжүүлвэл дараах томъёогоор тооцно.

$$T_x = \frac{A_{\text{Шмах}} + (A_{\text{Шмах}} * \text{НГх})}{A_{\text{Жэ/х}}}$$

$T_x$ -хонины тоо,

$A_{\text{Шмах}}$ -махан ашиг,

$\text{НГх}$ -нядалгааны гарцыг өсгөх хэмжээ ( $\frac{46}{100} = 0.46$ ),

$A_{\text{Жэ/х}}$ = хонины амьдын жин /дундажаар/

$$T_x = \frac{1462376.3 + (1462376.3 * 0.46)}{52.2} = 40901.7$$

Хонины сүү бий болгох чадавхийг дараах хүснэгтээр тооцно.

## Хүснэгт 9. Хонины сүү бий болгох чадавх

Хүйс	Тоо, толгой	Нэгжээс авах сүү /л/	Бүгд /л/
Эм хонь	56607	30	1698210

Хонины ноос бий болгох чадавхийг даарх хүснэгтээр тооцно.

## Хүснэгт 10. Хонины ноос бий болгох чадавх

Д/д	Нас	Тоо, толгой	Нэгжээс авах ноос /кг/	Бүгд /кг/
1	1.5	69230	1.3	89999
2	2.5	72171	1.7	147228.8
3	3.5		2	0
4	Хээлтүүлэгч	765	1.7	2210.85
	Бүгд	142166		239438.7

Арьс нэхий, дайвар бүтээгдэхүүн /толгой, цувдай, өлөн/ бий болгох чадавхи нь дээрх хүснэгтэнд тооцсон хонин толгой 142166 тэнцүү тооны байна. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг дараах хүснэгтээр тооцов.

Хүснэгт 11. Бэлчээрийн газрын бүтээгч чадавх

Мах			Сүү			Ноос			Арьс			Дайвар бүтээгдэхүүн			Бүгд дүн /төгрөг/
Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /л/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	
40901.71	5000	204508550	1698210	1400	2377494000	157135.7	1500	235703550	142166	500	71083000	14266	2500	355415000	3244204100

Дээрх хүснэгтээс харахад Дарви сум нь 512859.439 га бэлчээрийн газрын бүтээгч чадавхи 3244204100 төгрөг болж байна.

Эндээс 1 га бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээг дараах томъёогоор тооцож үзвэл

$$БЧга = \frac{БЧ}{S} = \frac{3289113213 \text{ төг}}{512859.439 \text{ га}} = 6413.2 \text{ төгрөг}$$

### 2.2.3 Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг тооцох /Ямаан сүрэг/

Монголчууд эрт дээр үеэс өсгөн үржүүлж ирсэн таван хошуу малын нэг бол ямаан сүрэг Төв Азийн цаг уурын нөхцөлд бэлчээрээр маллахад зохилдсон, биологи аж ахуйн өвөрмөц онцлогтой, ялангуяа говь, цөлөрхөг хээр, уулархаг нутгийн бэлчээр чадамгай ашиглаж, хөнгөн, хүнсний үйлдвэрийн чухал түүхий эд бүтээдэг аж ахуй билээ. Ямааны мах, ноолуур ба түүний сүүг өргөн ашигладаг. Сүүгээр нь бяслаг ба олон төрлийн цагаан идээ хийнэ. Цагаан болон хар ямааны сүүг эмчилгээний зориулалтаар болон эмийн бэлдмэл хийхэд ашигладаг.

Ямааны махны ашиг шимийг бий болгох боломжийг дараах томъёогоор бодож гаргана.

$$M_T = \frac{\left[ \frac{AJ_T}{100} + (AJ_D - AJ_T) \right] H_T}{100}$$

M<sub>T</sub>-Тухайн насны малын махны жилийн өсөлт буюу үйлдвэрлэгдэж буй махны хэмжээ

АЖД-Дараах насны малын амьдын жин

АЖТ-Тухайн насны малын амьдын жин

НГ-Тооцож буй малын нядалгааны гарц

Хүснэгт 12. Нядалгааны гарц тооцох хүснэгт

Д/д	Малын төрөл	Нядалгааны гарц, хувиар
1	Үхэр	55-65
2	Хонь, ямаа	44-48
3	Адуу	47-54
4	Тэмээ	55-65

Хүснэгт 13. Монгол ямааны махны гарц

Насны ялгаа	Амьдын жин /кг/	Гулуузын жин /кг/	Гарц /%/	Тухайн насны малын махны жилийн өсөлт
12 сартай	25.5	12.1	47.6	1.7
1.5 настай	28.9	13.4	49.6	2.5
2.5 настай	29.3	16	49.5	6.5
3.5 настай	34	19.1	49.1	7.5
4.5 настай	48.9	22	50.4	11.4
5.5 настай	71	38.8	54.6	

Хүснэгт 14. Ямаан сүргийн зохистой харьцаа

Д/д	Нас	Сүрэгт эзлэх хувь	Бүгд
1	1.5	48.5	45990
2	2.5	50.9	48241
3	Хээлтүүлэгч	0.5	545
	<b>Бүгд</b>	<b>100</b>	<b>94776</b>

Ямааны махыг бусад малын махны адил хүнсэнд хэрэглэдэг ба онцлог нь ямаа мах булчиндаа гадар өөх багатай, өөхөн сүүлгүй, харин дотор өөхний хуримтлал ихтэй, ямааны мах өөхний нядлагын гарц 40-45 хувь байдаг. Ямааны өлөн гэдэс хиамны үйлдвэрийн чухал түүхий эд болох ба эврээр нь жижиг сам, цаасны хутга зэрэг эдлэл, туурайгаар нь цавуу хийдэг байна. Ямааны ясаар янз бүрийн ясан эдлэл хийж болохоос гадна нунтаглаж малын тэжээлийн хольц, газар тариалангйн сайн бордоо бэлтгэдэг.

Ямааны маханд нийтдээ 15 нэрийн амин хүчил илэрсэн ба борог маханд агуулагдах үл орлогдох амин хүчлийн хэмжээ өөхтэй махныхаас харьцангуй их тодорхойлогдсон байна. Ямааны мах олон нэрийн хүчлээр баялаг, ханаагүй тосны хүчлийн агууламж өндөр (45.7-49.1%) төдийгүй уургийн үл орлогдох амин хүчил (44.0-39.0%) ихтэй чанартай мах хэмээн тодорхойлжээ (Л.Чой-Иш, 2005).

Монгол ямаа бэлчээрээр таргалах чадвар сайтай бөгөөд намар бүдүүн ухна 55-58, эм ямаа 37-41, шүдлэн ухна 35-38, охин шүдлэн 29-31 кг жин дардаг. Ямааны махны ашиг шимийг бий болгох боломжийг тооцож гаргавал дараах байдалтай байна.

Хүснэгт 15. Ямааны махны ашиг шим

Нас	Амьдын жин	Гулуузны жин	Нядлагын		Малын нэмэгдэх махны хэмжээ /кг/	Малын тоо	Нийт нэмэгдэх махны хэмжээ /кг/
			жин	хувь			
1.5	36.9	16	18.3	47.6	1.7	45990	78183
2.5	42.9	19.1	21.1	49.6	2.5	48241	120602.5
3.5	48.9	22	24.7	49.5	7.5		0
Хээлтүүлэгч	52.2	24.7	26.9	49.1	11.4	545	6213
<b>Бүгд</b>						<b>94776</b>	<b>204998.5</b>

Дээрх хүснэгтээр тооцсон махыг ямаан толгойд шилжүүлвэл дараах томъёогоор тооцно.

$$T_x = \frac{AШмах + (AШмах * НГх)}{АЖэ/х}$$

$T_x$  - ямааны тоо,

$AШмах$  - махан ашиг,

$НГх$  - нядалгааны гарцыг өсгөх хэмжээ ( $\frac{46}{100} = 0.46$ ),

$АЖэ/х$  - ямааны амьдын жин /дундажаар/

$$T_x = \frac{495961.1 + (495961.1 * 0.46)}{43.8} = 6833.2$$

Ямааны сүүний ашиг шимийг Д.Цэрэнсодном нэлээд сайн судалж, говийн нөхцөлд ямааны саалын хугацаа 225 хоног үргэлжилж, 60-70 литр сүү саалгадаг, сүүний гарц саалийн эхэн үед бага, дунд үеэр ихсэж, сүүл үе рүүгээ дахин багасдаг, харин ямааны сүүний гарц зургаа, долдугаар саруудад ихсэж, дээд хэмжээндээ хүрэх ба хоногийн саам 108-412 гр, сарынх 3.24-12.36 литр хүрнэ. Р.Индра нарын судалгаагаар говийн ямааны сүүний хуурай бодис 15.44-0.06 хувь, тос 5.81-0.03 хувь, нийт уураг 3.87-0.03 хувь, лактоз 4.87-0.29 хувь, үнс 0.89-0.019 хувь байжээ.

Ямааны саалийн хугацаа 7 сар үргэлжилж, 60-70 литр сүү өгдөг. Сүү ашиглах гол үе нь 6-р сарын 1-нээс 8-р дугаар сарын 15-ныг хүртэлх хугацаа бөгөөд ямаа бүрээс таваарын 20-30 литр сүү ашиглана. Ямааны сүү бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцно.

## Хүснэгт 16. Ямааны сүү бий болгох чадавх

Хүйс	Тоо, толгой	Нэгжээс авах сүү /л/	Бүгд /л/
Эм ямаа	38649	25	966225

Ямаан сүргийн тархалт дэлхийн өндөр уудам нутгийг хамрах учир тухайн улс орны цаг агаарын эрс халуун эсвэл бүр сэрүүн байдлаас хамаарч ямаа элгэн халцгай эсвэл хэт ноосорхог, зарим нь ноолууртай байдаг. Нэг ямаанаас дунджаар 250 грамм ноолуур гардаг. Нэг грамм цэвэр ноолуураар 9-10 метр утас ээрдэг. Монгол улс нь дэлхийн нийт ноолуурын 35-40% гаруй хувийг бэлтгэдэг. Монгол ямааны ноолуурын ширхэгийн голч 13.0-16.5 мкм дундаж урт 38-45 мм бөгөөд монголын эрс тэс цаг ууртай холбогдон дулаан хадгалах чанараараа бусад орны ямааны ноолуураас давуу байдаг. Ямааны ноолууран бүтээгдэхүүн нь хөнгөн, уян зөөлөн, дулаан хадгалах болон хэлбэрээ хадгалах чадвар онцгой сайн, тансаг бүтээгдэхүүн бөгөөд зах зээлд байнгын эрэлт хэрэгцээтэй байдаг.

Ухна 250-350, эм ямаа 240-270, борлон ухна 200-240, охин борлон 200-230, эр ямаа 240-380 гр ноолуур өгдөг.

Ямааны ноолуур бий болгох чадавхийг доорх хүснэгтээр тооцно.

## Хүснэгт 17. Ямааны ноолуур бий болгох чадавх

Д/д	Нас	Тоо, толгой	Нэгжээс авах ноолуур /кг/	Бүгд /кг/
1	1.5	45990	0.19	8738.1
2	2.5	48241	0.21	10130.61
3	3.5		0.3	0
4	Хээлтүүлэгч	545	0.35	190.75
<b>Бүгд</b>		<b>94776</b>		<b>19059.5</b>

Арьс нэхий, дайвар бүтээгдэхүүн /толгой, цувдай, өлөн/ бий болгох чадавхи нь дээрх хүснэгтэнд тооцсон нийт ямаан сүргийн тоотой тэнцүү 94776 байна.

2015 оны эцсийн байдлаар Дарви сумын нийт ямаан сүргийн ашиг шимийг мах, сүү, ноолуур, арьс, дайвар бүтээгдэхүүнээр тооцож үзэв.

Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийг дараах хүснэгтээр тооцов.

Хүснэгт 18. Бэлчээрийн газрын бүтээгч чадавх

Мах			Сүү			Ноолуур			Арьс			Дайвар бүтээгдэхүүн		
Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /л/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /кг/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд	Бий болгох /ш/	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд
6833.2	4000	27332800	966225	1000	966225000	19059.5	55000	1048272500	94776	500	47388000	94776	2500	236940000
														2326158300

Дээрх хүснэгтээс харахад Дарви сум нь 512859.439 га бэлчээрийн газрын бүтээгч чадавхи 23261583 төгрөг болж байна.

Эндээс 1 га бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээг дараах томъёогоор тооцож үзвэл

$$БЧга = \frac{БЧ}{S} = \frac{2326158300 \text{ төг}}{512859.439 \text{ га}} = 4535.6 \text{ төгрөг}$$

Бэлчээрийн газрын суурь үнэлгээг тооцохын тулд дараах 3 байдлаар үнэлж тооцлоо.

Үүнд:

4. Хөрсийн чанарын үнэлгээ /Хчү/
5. Бэлчээрийн газрын бүтээгч чадавхийн үнэлгээ /БГбчү/
6. МАА үйлдвэрлэлийн бизнес тооцооллын аргаар үнэлсэн үнэлгээ /Окү/

Дээрх 3 үнэлгээгээр бэлчээрийн газрын суурь үнэлгээ/Гсү/ гарах юм.

$$Гсү = Хчү + БГбчү + МААб$$



## ГУРАВ. СУМЫН ГАЗРЫН ТОХИРОМЖТОЙ БОЛОН ХЭРЭГЦЭЭТ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ


### 3.1 Сумын газрын тохиромжтой байдлын үнэлгээ

ГХГЗЗГ-ын даргын тушаалын 2015 оны 9-р сарын 9-ний өдрийн А/200 тоот Газрын тохиромжтой байдлын үнэлгээний аргазүй, шалгуур үзүүлэлтүүд батлах тухай тушаалд зааснаар Дарви суманд бэлчээр, тариалан, хот суурин, ой, зам, шугам сүлжээ болон аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээг дараахь шалгуур аргачлалын дагуу хийсэн.

#### 3.1.1 Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Тухайн орон нутаг, бүс нутгийн бэлчээрийн ургамлын анги, бүлэг төрөл, идэмж, байгалийн бүс бүслүүр, гадаргын нөхцөл, усан хангамж, бэлчээрийн хэв шинж зэрэг үзүүлэлтэд үндэслэн үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Хадлан, бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ”-г боловсрууллаа. Хадлан, бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг бэлчээрийн ургамлын 250 анги, бүлэг төрлөөр 7 үндсэн үзүүлэлтэд үндэслэн гүйцэтгэлээ.

График 1.Бэлчээрийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний схем



Хүснэгт 19. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га /Өвөл-Хавар/



Д/д	Үнэлгээ	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
1	Бусад газар ашиглалт	21665.77	21655.20	21640.08	21674.49	21674.49
2	Тохиромжгүй	7864.58	112364.56	45778.51	1610.29	1610.29
3	Дунд зэрэг тохиромжтой	149474.07	229271.70	70769.88	58832.50	58832.50
4	Тохиромжтой	331627.77	146317.30	88655.52	321330.3 3	321330.3 3
5	Нэн тохиромжтой	43880.50	44903.89	327668.6 5	151065.0 5	151065.0 5

Хүснэгт 20. Таван хошуу малд тохиромжтой газрын хэмжээ, хувь /Өвөл-хавар/


Үнэлгээ	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Бусад газар ашиглалт	3.9	3.91	3.9	3.91	3.91
Тохиромжгүй	1.42	20.26	8.26	0.29	0.29
Дунд зэрэг тохиромжтой	26.9	41.35	12.76	10.61	10.61
Тохиромжтой	59.8	26.39	15.99	57.95	57.95
Нэн тохиромжтой	7.9	8.1	59.09	27.24	27.24

Дарви сумын нутагт мал аж ахуй өсгөн үржүүлэхэд тохиромжтой үзүүлэлт гарч байна. Мал аж ахуйд нийт нутгийн 16-60 % нь тохиромжтой, 8-27% нь нэн тохиромжтой, 0.3- 21% нь тохиромжгүй, 11-42 % нь дунд зэргийн тохиромжтой гэсэн үзүүлэлт гарч байна. Бусад газар ашиглалтанд нийт нутгийн 4% нь хамарч байна.


График 2. Таван хошуу малд тохиромжтой газрын хэмжээ, хувь




### Тэмээ




### Ямаа




### Хонь







Зураг 3. Өвөл-Хаврын улиралд адуунд тохирох бэлчээрийн зураг




Зураг 4. Өвөл-Хаврын улиралд үхэрт тохирох бэлчээрийн зураг



Зураг 5. Өвөл-Хаврын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн зураг



Зураг 6. Өвөл-Хаврын улиралд хонинд тохирох бэлчээрийн зураг.



Зураг 7. Өвөл-Хаврын улиралд ямаанд тохирох бэлчээрийн зураг

Хүснэгт 21. Бэлчээрт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га /Зун-Намар/


Д/д	Үнэлгээ	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
1	Бусад газар ашиглалт	21652.44	21633.02	21650.21	21665.07	22475.51
2	Тохиромжгүй	8851.75	1997.06	23165.26	3324.74	4135.18
3	Дунд зэрэг тохиромжтой	76378.72	255167.08	73418.31	110365.37	111175.81
4	Тохиромжтой	287388.58	219510.30	117889.72	415915.71	416726.15
5	Нэн тохиромжтой	160241.17	56205.20	318389.14	-	-






Хүснэгт 22. Таван хошуу малд тохиромжтой газрын хэмжээ, хувь /Зун-намар/

Үнэлгээ	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Бусад газар ашиглалт	3.90	3.90	3.90	3.93	4.05
Тохиромжгүй	1.60	0.36	4.18	0.60	0.75
Дунд зэрэг тохиромжтой	13.77	46.02	13.24	20.02	20.05
Тохиромжтой	51.83	39.59	21.26	75.45	75.15
Нэн тохиромжтой	28.90	10.14	57.42	-	-


График 3. Таван хошуу малд тохиромжтой бэлчээрийн эзлэх хувь /Зун-намар/









Зураг 8. Зун-Намрын улиралд адуунд тохирох бэлчээрийн зураг




Зураг 9. Зун-Намрын улиралд үхэрт тохирох бэлчээрийн зураг



Зураг 10. Зун-Намрын улиралд тэмээнд тохирох бэлчээрийн зураг



Зураг 11. Зун-Намрын улиралд хонинд тохирох бэлчээрийн зураг



Зураг 12. Зун-Намрын улиралд ямаанд тохирох бэлчээрийн зураг

**3.1.2 Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ**

Дарви сумын байгаль орчин, уур амьсгал, газарзүйн бүс, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгч үзүүлэлтийг нэгтгэн “Тариалангийн газрын тохиромжтой байдлын иж бүрэн үнэлгээ”-г боловсрууллаа.


Тариаланд тохиромжтой газрын иж бүрэн үнэлгээ өгөхдөө хүрээлэн буй орчныг нэгдсэн систем гэж үзэж, байгаль болон нийгэм эдийн засгийн хүчин зүйлүүдийг хослуулж

5 шатлалтай ангиллаар үнэлгээний хүчин зүйлсийн үзүүлэлт бүрт тохируулан тогтоосон онооны (баллын) аргаар үнэлгээг боловсруулна. Үүнд:

1. Геофизик хүчин зүйлийн үнэлгээ
  - 1.1. Газрын гадаргын үнэлгээ;
  - 1.2. Гидрологийн үнэлгээ;
  - 1.3. Инженер-геологийн үнэлгээ;
  - 1.4. Хөрсний үнэлгээ;
2. Уур амьсгалын үнэлгээ
  - 2.1. Агаарын температур;
  - 2.2. Хур тунадас;
  - 2.3. Дулаан хангамжийн нөхцөл;
  - 2.4. Чийг хангамжийн нөхцөл;
3. Газар ашиглалтын суурь нөхцлийн үнэлгээ
  - 3.1. Ой бүхий талбай;
  - 3.2. Хот суурингийн газар;
  - 3.3. Зам, шугам сүлжээний газар;
  - 3.4. Тариалангийн талбай;
  - 3.5. Уул уурхайн талбай;
  - 3.6. Түүх соёлын дурсгалт газар;
  - 3.7. Археологийн үнэт олдвор;
  - 3.8. Гол, мөрөн;
  - 3.9. Булаг, худаг уст цэг;
  - 3.10. Манхан элс;

Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээг хийхэд График-9-д тусгагдсан нийт 3 үндсэн, 29 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэсэн.

График 4. Тариалангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд







Хүснэгт 23. Тариаланд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	20611.65	3.72
Нэн тохиромжгүй	59396.94	10.71
Тохиромжгүй	187934.18	33.89
Хязгаарлагдмал тохиромжтой	282276.93	50.91
Тохиромжтой	4292.96	0.77

График 5. Тариалангийн газрын тохиромжтой байдлын эзлэх хувь



Дарви сумын хувьд газар тариаланд тохиромжтой 178 мян.га орчим га газар байна. Мөнгөн-Аяга багийн төв орчим, Дэлгэр багийн Дэлгэрийн хөл орчимын газар нь тариалангийн газарт тохиромжтой байна.



Зураг 13. Тариалангийн тохиромжтой байдлын үнэлгээний зураг

### 3.1.3 Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ


Зорилго нь Монгол оронд хот, суурин газар байгуулахад тохиромжтой болон тохиромжгүй бүс нутгийг үнэлэх ажлыг нэгдсэн зааварчилгаагаар хангахад оршино.

Шинээр байгуулах хот суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээ хийхэд шаардагдах хүчин зүйл, тэдгээрийн шалгуур үзүүлэлтийн талаар Монгол улсын Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны 2010 онд боловсруулсан "Хот, суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар" (УББ 30-201-09)-т бүрэн тусгагдсан учраас энэхүү батлагдсан баримт бичигт үндэслэн тохиромжтой байдлын үнэлгээг хийнэ. Ингэхдээ дээрх аргачилсан зааварт тусгагдсан 4 үндсэн, 43 дэд үзүүлэлтээс 3 үндсэн 19 дэд үзүүлэлтийг хэвээр үлдээж, 1 үндсэн, 16 дэд үзүүлэлтийг шалгуур үзүүлэлтийг боловсруулсан. Үүнд:

Тухайн орон нутаг, бүс нутгийн байгаль орчин, уур амьсгал, инженер геологийн нөхцөл, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Шинээр байгуулах хот суурины дэвсгэр газрын тохиромжтой байдлын иж бүрэн үнэлгээ”-г боловсруулна.


Шинээр байгуулах хот суурины дэвсгэр газрын тохиромжтой байдлын үнэлгээг хийхэд График-29-д тусгагдсан нийт 3 үндсэн, 35 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ.

График 6. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээний



Хүснэгт 24. Шинээр байгуулах хот, суурин газарт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	20228.66	3.6
Тохиромжгүй	75535.3	13.6
Хязгаарлагдмал тохиромжтой	376829.07	67.9
Тохиромжтой	81916.9	14.7



Зураг 14. Шинээр байгуулах хот, суурин газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг

### 3.1.4 Аялал жуулчлалын газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Байгалийн нөөц рекреацийн нутаг дэвсгэр ашиглалтын урьдчилсан нөхцлүүдийн нэг гол хүчин зүйл, байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийн төдийгүй түүний иж бүрдлийг бүхэлд нь хамардаг онцлогтой юм.


Дарви сумын Ландшафт-рекреацийн чадавхийн үнэлгээнд дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзэж шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Үүнд:

1. Ландшафтын үнэлгээ

- 1.1.Газрын гадаргын аялал-рекреацийн үнэлгээ
- 1.2.Уур амьсгалын аялал-рекреацийн үнэлгээ
- 1.3.Гадаргын ус- рашааны аялал-рекреацийн үнэлгээ
- 1.4.Био нөөцийн аялал-рекреацийн үнэлгээ
- 1.5.Ландшафтын гоо зүйн үнэлгээ
2. Байгаль, түүх, соёлын дурсгалт газрын үнэлгээ
  - 2.1.Байгаль-соёлын дурсгалт газар
  - 2.2.Түүх- соёлын дурсгалт газар
3. Дэд бүтцийн үнэлгээ
  - 3.1.Гатлага, зам (даваа, ус, элс, намаг, шавар, сөөгөн ширгэнэ)
  - 3.2.Хот болон байнгын оршин суух газарт ойрхон эсэх
  - 3.3.Тохижилтын түвшин
4. Газар ашиглалтын суурь нөхцөлийн үнэлгээ
  - 4.1.Тариалангийн талбай
  - 4.2.Одоо байгаа хот суурин газар
  - 4.3.Уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай
  - 4.4.Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн онгон болон онцгой бүс

Тухайн орон нутаг, бүс нутгийн ландшафт, байгаль, түүх, соёлын дурсгалт, дэд бүтэц, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Байгалийн аялал- рекреацийг хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн үнэлгээ”-г боловсруулна. Байгалийн аялал-рекреацийг хөгжүүлэхэд тохиромжтой газар нутгийн үнэлгээг 3 шатлалтай ангиллаар нийт 4 үндсэн, 27 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ.

График 7. Ландшафтын үнэлгээний схем





Хүснэгт 25. Аялал жуулчлалын газарт тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	22335.19	4.03
Тохиромжгүй	30964.63	5.58
Хязгаарлагдмал тохиромжтой	338116.45	60.97
Тохиромжтой	163103.80	29.41

Тус сумын нутагт аялал жуулчлал хөгжүүлэх боломж нөхцөл байгаа бөгөөд нийт нутгийн 60.97 % нь тохиромжтой байна.

График 8. Аялал жуулчлалын газарт тохиромжтой газрын эзлэх хувь






Зураг 15. Аялал рекреацийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг

**3.1.5 Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээ**

Тухайн орон нутаг, бүс нутгийн байгаль орчин, уур амьсгал, инженер геологийн нөхцөл, газар ашиглалтын онцлогоос хамаарч үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын үнэлгээ”-г боловсруулна.

Шугаман байгууламжийн зориулалтаар ашиглах газрын үнэлгээг хийхэд зураг 1-д тусгагдсан нийт 3 үндсэн, 6 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ.

График 9. Шугаман байгууламжийн тохиромжтой байдлын үнэлгээ




Хүснэгт 26. Авто замд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

Д/д	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Нэн хүндрэлтэй	115573.11	20.84
2	Хүндрэлтэй	90925.66	16.4
3	Хэвийн	348019.08	62.76


Хүснэгт 27. Шугам сүлжээд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

Д/д	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Нэн хүндрэлтэй	198199.46	35.74
2	Хүндрэлтэй	9302.12	1.68
3	Хэвийн	347014.51	62.58





Зураг 16. Авто зам болон төмөр замын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг




Зураг 17. Цахилгаан дамжуулах агаарын шугамын зориулалтаар ашиглах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг

**3.1.6 Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээ**

Тухайн орон нутаг, бүс нутгийн ой- ургамалжилын муж, хошуу, өндрийн бүслүүр ангилалд үндэслэн гадаргын нөхцөл, хөрсний шинж чанарыг илтгэх үндсэн болон дэд үзүүлэлтийг сонгон үнэлгээ өгөх ба эдгээр үзүүлэлтийг нэгтгэн “Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээ”-г боловсруулна. Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээг байгалийн 3 өөр муж, 9 хошуу, өндрийн бүслүүрээр ялгаатай 22 ойн хэв шинжид үндэслэн нийт 3 үндсэн, 11 дэд үзүүлэлтийг үндэслэн гүйцэтгэнэ.


График 10. Ойн сангийн тохиромжтой байдлын үнэлгээ



Хүснэгт 28. Ой санд тохиромжтой газрын талбайн хэмжээ, га

Д/д	Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
1	Бусад газар ашиглалт	22264.77	4.02
2	Тохиромжгүй	504434.07	90.97
3	Хязгаарлагдмал тохиромжтой	27335.41	4.93
4	Тохиромжтой	486.04	0.09
Нийт талбай		554512.6	100.0

Дарви сумын ойн тохиромжтой байдлын үнэлгээгээр нийт нутгийн 90.97 % нь ойд тохиромжгүй гэж гарчээ. Нийт нутгийн 5 % нь ойд хязгаарлагдмал тохиромжтой гэсэн үнэлгээтэй байна. Дарви сум нь ойн газар бага байгаа нь ойг хөгжүүлэх боломж сулыг харуулж байна.



Зураг 18. Ойн сангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг

### 3.1.7 Усан сан, хөв цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Хөв цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын тогтоохдоо байгалийн болон хүний хүчин зүйлийг харгалзан үздэг. Байгалийн хүчин зүйл


1. Хонхор хотгор газрын хэмжээ
2. Гадаргын урсгалын чиглэл
3. Ус урсах талбай
4. Газрын хэвгий
5. Хөрсний ус нэвчиц
  - 5.1 Намагших буюу ус үл нэвчүүлэх гадарга-байгалийн тогтоц
  - 5.2 Инженерийн хийц ус үл нэвчүүлүүлэх гадарга үүсгэх
6. Хур тунадасныхэмжээ
7. Ууршиц
8. Урсцын модуль
9. Ойн сан

Хүний хүчин зүйл

1. Газар тариалан
2. Авто зам
3. Хот суурин
4. Уул уурхай
5. Газар ашиглалтын бусад хэлбэр зэрэг хүчин зүйлийг харгалзах өндрийн тоон

загвар, гадаргын усны сүлжээ, газар тариалан, авто зам, хот суурин , ойн сан, уул уурхай, засаг захиргааны нэгж, хөрс, байр зүйн зураг, хур тунадас, агаарын хэм, харьцангуй чийгшил зэргийн мэдээг ашиглан хөв цөөрөм байгуулах тохиромжтой байдлын үнэлгээг гаргалаа.

Эдгээр үзүүлэлтийг харгалзан үзэхэд Дарви суманд нийт 1 газар тохиромжтой 5 газар дунд зэргийн тохиромжтой гэсэн үнэлгээ гарч байна.



Зураг 19. Хөв цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг

### 3.1.8 Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээ

Газар нутгийн хадгалан хамгаалах нь хүмүүний оршин тогтнох эх үндэс болсон газар, хүмүүсийн амьдралыг тэтгэгч ус, цэвэр агаар, эрүүл орчинг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй билээ. Түүнчлэн биологийн төрөл зүйлийн нөөцийг тогтвортой, эрүүл байлгах, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад бидний амьдарч буй орчин нөлөөлдөг. Иймээс эдгээр шинж чанарыг авч үлдэхийн тулд хадгалан хамгаалах зайлшгүй шаардлагатай.

Хадгалан хамгаалах газрын үнэлгээ хийхдээ хамгаалах амьтан, ургамлын зүйлийг тодорхойлохоос эхэлдэг бөгөөд дараах аргыг хэрэглэдэг. Үүнд:

- Амьдрах орчны хамгаалал болон газар нутгийг тусгай хамгаалалтанд авах, байгаль орчны төлөвлөгөө боловсруулах
- Уул уурхай болон эрчим хүчний хөгжил тэдгээрийн нөлөөг бууруулах
- Биологийн судалгаа болон хяналт шинжилгээ
- Экосистемийн үйлчилгээний үнэлгээний хүрээнд бэлчээр болон усны нөөцийг тогтоох зэрэг ашигладаг.

Амьтны зүйлийн тархацын загвар гаргахад дараах мэдээллийг ашиглана. Үүнд:


Амьдрах орчны тодорхойлолт- тухайн зүйлийн амьдрах орчны физик шинж чанар болон хүрээлэн буй орчны тодорхойлолт

- Ажиглалт судалгааны мэдээ
- Идэж тэжээл
- Өндөршил
- Гадаргын хэлбэр
- Экосистемийн ангилал
- Хур тунадас зэрэг болно.

Дарви сумын хадгалан хамгаалах тохиромжтой газрын үнэлгээгээр нийт нутгийн 36 хувийг хадгалан хамгаалахад тохиромжтой газар гэж гарсан байна.

*Хүснэгт 29. Хадгалан хамгаалахад тохиромжтой газар*

Үнэлгээ	Талбай, га	Эзлэх хувь
Бусад газар ашиглалт	355743.29	64.15
Хадгалан хамгаалахад тохиромжтой газар	198769.36	35.85
<b>Нийт</b>	<b>554512.652</b>	<b>100.00</b>



Зураг 20. Хадгалан хамгаалах газрын тохиромжтой байдлын үнэлгээний зураг



### 3.2 Орон нутгийн хэрэгцээт байдлын үнэлгээ

Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөнд нутгийн иргэдийн оролцоо хамгаас чухал. Төлөвлөгөө боловсруулахдаа иргэдийн оролцоог хангаж орон нутгийн хэрэгцээт байдлын үнэлгээг гаргах үүднээс үүднээс малчин, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 25%, сумын засаг даргын тамгын газрын ажилтнуудын 70%-ийг судалгаанд хамруулсан болно.

Орон нутгийн иргэд оролцож, тэдний санал тусгагдаж байж төлөвлөгөө хэрэгжих боломж хангагдана. Иймээс Дарви сумын иргэдийн оролцоотойгоор сумын нийгэм эдийн засгийн хөгжлийн SWOT шинжилгээ хийж, АНР (Analytic Hierarchy Process) буюу хүчин зүйлсийг хоёр хоёроор нь харьцуулж үнэлгээ өгөх аргаар хүчин зүйлст үнэлгээ өглөө. SWOT төлөвлөгөөний хэлэлцүүлэгт төсөвт байгууллага, малчид, бизнес эрхлэгчид зэрэг янз бүрийн байгууллагуудаас хүмүүс оролцсоноос гадна залуучууд, ахмад, эмэгтэйчүүдийн зэрэг нийгмийн янз бүрийн давхаргыг төлөөлсөн 30 орчим хүн оролцлоо. Олон нийтийн оролцоотой тодорхойлж, үнэлсэн SWOT шинжилгээний үр дүнг 28 хүснэгтээр харуулав.

Хүснэгт 30. SWOT шинжилгээний үр дүн

Хүчин зүйлс, хувийн жин		Дэд хүчин зүйлс	Дэд хүчин зүйлийн хувийн жин	Ерөнхий хувийн жин
Дотоод	Давуу тал (S) 0.17	S1: Мал аж ахуйн үйлдвэрлэл сайн хөгжсөн (Сутай омгийн хонь)	0.50	<b>0.082</b>
		S2: Тариалан эрхлэх талбайн нөөцтэй	0.08	0.013
		S3: Дэд бүтэц сайн хөгжсөн, Говь-Алтай болон Ховд аймгийн төвтэй хар замаар холбогдсон	0.21	<b>0.035</b>
		S4: Аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөцтэй	0.08	0.014
		S5: Ашигт малтмалын нөөц ихтэй (Хөшөөтийн уурхай)	0.12	<b>0.021</b>
	Сул тал (W) 0.44	W1: Аймгийн төв болон нийслэлээс алслагдмал	0.17	<b>0.076</b>
		W2: Үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх санхүүжилт дутмаг	0.05	0.023
		W3: Малын тоо толгой нэмэгдэх хандлагатай	0.39	<b>0.174</b>
		W4: Хүн хүчний нөөц дутмаг, залуучууд төв бараадах сонирхолтой болсон	0.10	0.042
		W5: Жижиг, дунд үйлдвэрийн хөгжил сул	0.29	<b>0.129</b>
Гадаад	Боломж (O) 0.11	O1: Ховд, Говь-Алтай аймгийн зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлэхэд хялбар байдал	0.09	0.009
		O2: Засгийн газар, аймгийн ЗДТГ-аас орон нутгаас төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	0.16	0.017
		O3: Хөшөөтийн уурхайгаас сумын бизнес эрхлэгчид, иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх	0.27	<b>0.029</b>
		O4: Хүн амын бэлэнчлэх сэтгэлгээ өөрчлөгдөж, хувиараа бизнес эрхлэх хандлагатай болж байгаа	0.48	<b>0.052</b>
		T1: Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, цөлжилт нэмэгдэх хандлагатай	0.35	<b>0.100</b>

Аюул занал (Т)	T2: Хог хаягдал нэмэгдэх хандлагатай	0.13	0.037
	T3: Хүн амын өөрийгөө болж байвал бусад нь хамаагүй гэсэн хандлага, сэтгэлгээ нэмэгдэх хандлагатай	0.35	<b>0.100</b>
	T4: Малын өвчин нэмэгдэж, малын чанар муудах, давжаарах хандлагатай болсон	0.16	0.046

Олон нийт Дарви сум нь нийгэм, эдийн засгийн хувьд сул тал (0.44), аюул занал (0.28) давамгайлсан, давуу тал (0.17), боломж (0.11) багатай гэж үзжээ. Хүчин зүйлсийг хооронд нь харьцуулж үнэлэхэд сумын хөгжлийн хамгийн гол **давуу тал** нь *Мал аж ахуйн үйлдвэрлэл сайн хөгжсөн, ялангуяа мах, ноосны чиглэлийн Сутай омгийн хонь үржүүлдэг, Дэд бүтэц сайн хөгжсөн, Говь-Алтай болон Ховд аймгийн төвтэй хар замаар холбогдсон, Ашигт малтмалын нөөц ихтэй, ялангуяа Хөшөөтийн Уурхай ажилладаг явдал, хөгжлийг тэтгэх боломж* нь *Хүн амын бэлэнчлэх сэтгэлгээ өөрчлөгдөж, хувиараа бизнес эрхлэх хандлагатай болж байгаа, Хөшөөтийн уурхайгаас сумын бизнес эрхлэгчид, иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх явдал* гэж дүгнэжээ. Харин сумын үндсэн **сул тал** нь *Малын тоо толгой нэмэгдэх хандлагатай, энэ нь бэлчээр, байгальд сөргөөр нөлөөлж болзошгүй, Жижиг, дунд үйлдвэрийн хөгжил сул, Аймгийн төв болон нийслэлээс алслагдмал, харин Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, цөлжилт нэмэгдэх хандлагатай, Хүн амын өөрийгөө болж байвал бусад нь хамаагүй гэсэн хандлага, сэтгэлгээ нэмэгдэх хандлагатай* байгаа нь нийгэм, эдийн засгийн хөгжилд учруулах **аюул занал** юм гэж дүгнэжээ.

Түүнчлэн иргэдийн саналыг төлөвлөгөөнд тусгуулах чиглэлээр арга зүйн дагуу ажиллаа.

Иргэдийн санал бодлыг нутаг дэвсгэрийн төлөвлөлтөнд тусгуулах, ашиглалтын олон хэлбэр бүхий газрын хэрэгцээг тодорхойлох нь сумын тогтвортой хөгжилд чухал ач холбогдолтой.

### 3.2.1 Малчин өрхийн хэрэгцээт байдлын үнэлгээ

Сумын хүн амын дийлэнхийг бүрдүүлэгч малчин өрхийн саналыг нутаг дэвсгэрийн төлөвлөгөөнд тусгуулан тэдний хэрэгцээг гаргуулах нь чухал билээ. Иймд сумын нутаг дэвсгэрийн төлөвлөлтөнд дараах байдлаар санал, хэлэлцүүлгийн зохион байгууллаа. Үүнд:

- Дарви сумын иргэд, хуулийн этгээд, малчин өрхөөс түүвэрлэх байдлаар санал авсан. Сумын төвийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа иргэдээс эхлэн хөдөөгийн малчдыг хамруулж саналын хуудсаар санал авсан.
- Багийн Иргэдийн нийтийн хурлаар багийн бүх иргэдийг хэлэлцүүлэх, санал авах. Дөрвөн багийн Иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулж тэдний саналыг авч төлөвлөгөөний загвар төслийг танилцуулж холбогдох санал хэлэлцүүлгийг хийж төлөвлөгөөндөө тусган энэхүү багийн Иргэдийн нийтийн хурлаас гарсан тогтоол,

шийдвэрүүдийг /тэмдэглэл/ зурагт буулган боловсруулалт хийж сумын Иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлаар оруулж хэлэлцүүлэн санал бодлыг авч төлөвлөгөөг боловсрууллаа. Малчдын хэрэгцээт байдлыг гаргахын тулд нийт 42 малчдаас санал авлаа. Малчдын саналын багцалж баг багаар харуулбал:

**Мөрөн баг:** Нийт 19 малчнаас 15 малчин санал өглөө. Малчны саналыг тоймлон үзвэл бэлчээр усжуулалт, хадлангийн газрыг өргөжүүлэх, эзэнжүүлэх, ан амьтан, ургамал амьтныг хамгаалах, гэрээ байгуулах, малын үүлдэр угсаа сайжруулах, мал эмнэлгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх, хөв цөөрөм байгуулах, морь барианы гал байгуулах газрыг тодорхойлж болгох газар төлөвлөх, зам засах зэрэг санал гарлаа. Малчдын гаргасан саналыг зурагт буулган тохиромжтой байдлын үнэлгээтэй тулган нутаг дэвсгэрийн төлөвлөгөөнд тусгаж болох боломжийг судлахаар боллоо. Мөрөн багийн иргэдийн нийтийн хурлаар бэлчээр ашиглалтын хэсэг болон төлөвлөгөөнд тусгуулах саналыг тусгуулан хэлэлцүүлээ.

**Мөнгөн аяга баг:** Нийт 28 малчдаас санал асуулга авснаас санал гаргасан 15 малчин байна. Малчдаас бэлчээр усжуулах, орон нутгийн тусгай хамгаалалтанд Мөнгөн овоо, Тунгалагын тал, Бумбатайн тал, уул, Цагаан сайр, Модот, Жинст, Жаргалант, Чулуутын нуруу, Цагаан нуруу, Шар булгын нуруу зэрэг байгалийн цогцолбор газрыг авах, гүүр барих, зам засах, мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, хурдан морины гал байгуулах газрыг төлөвлөх, ирвэс, хойлог, хар сүүлтийг хамгаалах, Мөнгөн аяганаас Тунгалаг хүртэл өвөлжөөний нутаг төлөвлөх, Шар булгын хөндий, уртын хөндийд зам тавьж сайжруулах ажлыг зохион байгуулах, дунд буудалд амралт зугаалгын газар болон Тангийн овооны хэсэгт амралт зургаалгын газар байгуулах, харилцаа холбооны шугам оруулах Алтан овоо, Дарцагт сүлжээ оруулах, хогийн цэгийг замбараатай болгох, зэрэг саналууд гарсан байна. Мөнгөн аяга багийн иргэдийн нийтийн хурлаар сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөтэй холбоотой багийн асуудлыг хэлэлцүүлсэн болно.

**Булаг баг:** Нийт 17 санал авснаас 7 санал гаргасан байна. Хурдан морины галын газрыг төлөвлөх, авто замын холбох боломжийг судлах, бэлчээрийн газрыг усжуулах зэрэг санал гарлаа. Бага борд байгаа эвдэрсэн худгийг засах хэрэгцээтэй. Малчдаас гарсан саналын Булаг багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлсэн боловч нэмэлт санал гарсангүй. Асуудлыг бүгдийг зөвшөөрсөн гэдгээ илэрхийллээ.

**Дэлгэр баг :** Нийт 15 санал авснаас 9 санал гаргасан. Цаст богд, Буурал богд, Сутай, нурууг тусгай хамгаалалтанд авах, Их сайрын замыг засах, Цаст уулын энгэрт зам тавих, Гурван Өлзийтийн нурууг хамгаалалтанд авах, Өлзийт уулын ам, Ноёны хүрэн, Могойн

хамрын даваа, Хийморийн бор толгойд амьтан вансэмбэрүү үзэх боломжтой учраас аялал жуулчлалаар төлөвлөлтөнд тусгуулах боломжийг судлахыг санал болголоо. Дэлгэр багийн иргэдийн нийтийн хурлаар бэлчээр ашиглалтын хэсгийн зааг болон төлөвлөгөөнд тусгуулах асуудал, улирлын хувиарийг малчдаар хэлэлцүүлсэн болно.

Иргэдээс авсан саналын судалгааг 4 малчдын жишээн дээр тоймлон хүснэгт 29 харууллаа.

Хүснэгт 31. Иргэдээс авсан саналын судалгаа/4 иргэний жишээн дээр/

№	Асуулт:	1	2	3	4
1	Санал өгөгчийн овог нэр	Содномдаржаа	Ц. Бямбацэрэн	Баярцэцэг	Д. Чүлтэмсүрэн
2	Төрөл	Иргэн	Иргэн	Эрдэнэ бэйс Сутай ТББ	Иргэн
3	Утас, хаяг	Мөрөн баг	Булган баг	Булган	Дэлгэх
			98565001	99624599	98187910
4	Санал	Хишигтийн дэнжийн урд үзүүрт хадлан авах	Ахуйн хэрэгцээнд	Бэлчээрийн аж ахуй	Уст цэг гаргах
5	Төслийн зориулалт	Газар тариалан /Эрүүл, аюулгүй, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах/	Мод үржүүлэх	Бэлчээрийн аж ахуй	Бэлчээр усжуулах
6	Туршлага	Туршлага байхгүй	Туршлага байхгүй	Туршлага байхгүй	Туршлага байхгүй
7	Нөөц боломж /өөрийн болон бусад/	Хадлангийн талбай хашиа хадлан авах боломжтой	Өөрийн болон төслийн хөрөнгөөр	Төрөөс санхүүжүүлэх	Төрөөс санхүүжүүлэх
8	Бусад газар ашиглалттай уялдаатай эсэх		Хүний болон автомашины нөлөөлөлд орсон	Ургамлын нөмрөг багассан	Өвс сайтай бэлчээр, усны гачигдалтай
Санал болгож буй төслийн мэдээлэл:					
9	Харьяалагдах засаг захиргаа, багийн нэр	Мөрөн	Булган	Булган	Дэлгэр
10	Байршил /координат/ газрын нэр	Хишигтийн дэнж	Холбооны дээд талд		Багийн нутаг дэвсгэрт
11	Шаардагдах талбайн хэмжээ	3 га	15м кв		
12	Хөрөнгө оруулалтын байдал	СХС, ЖДБЭС, Зээл, өөрийн хөрөнгөөр	Өөрийн болон төслийн	Улсын болон орон нутгийн	Хөрөнгийн туслалцаа шаардлагатай

13	Орон нутагт үзүүлэх нөлөөлөл	Ажлын байр нэмэгдэнэ	Эерэг		Мал, малчид бэлчээр нутагтай болно
14	Хэрэгжих хугацааны төсөөлөл /жил, сар/	5 – 10 жил			
15	Орон нутгийн хөгжилтэй уялдсан эсэх				Уялдсан
16	Байгаль орчин, түүнд үзүүлэх нөлөөлөл	Сөрөг нөлөө байхгүй	Сөрөг нөлөө байхгүй		

Нийт иргэдийн дийлэнх хувь нь бэлчээрийн талхлагдал, уст цэгийн хүрэлцээ хангамж муу, худаг уст цэг гаргах, орон нутгийн тусгай хамгаалалтанд байгалийн үзэсгэсэнт газруудаа оруулж хамгаалах мөн тариалангийн ашиглахгүй талбайг сэргэн ашиглаж усалтын системийг сэргээх, хадлангийн талбай хаших, уул уурхайн ойролцоо байгаа бүртгэлгүй иргэдийн асуудлыг шийдэх, улирлын бэлчээрийг зааглаж чанд мөрдөх, зуны бэлчээр шинээр хаваржаа олгохгүй байх, бэлчээрийг гэрээгээр ашиглах, өрхийн аж ахуй эрхлэх чиглэлээр санал өгсөн байна.

### 3.2.2 Иргэн, хуулийн этгээдийн хэрэгцээт байдлын үнэлгээ

Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөнд иргэдийн оролцоог хангахдаа малчин, төдийгүй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн саналыг авах зорилгоор сумын төвийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдээс нутаг дэвсгэрийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг авсан. Сумын төвийн үйлдэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэд ашиглаж буй газраа өөрийн эзэмшил, өмчлөлд авахаас өөр санал ирүүлээгүй байна.

Иргэдээс ирүүлсэн санал болон Дарви сумын нийгэм эдийн засгийн хөгжлийн SWOT шинжилгээний давуу, сул талуудыг үнэлсэн үнэлгээнд үндэслэн Дарви сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний үндсэн чиг хандлагыг гаргаж ирлээ.

## ДӨРӨВ. СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 4.1 Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө

Энэхүү төлөвлөгөөний чиг баримжаа нь Монгол улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн бодлого, аймгийн хөгжлийн бодлого, Дарви сумын хөгжлийн /2013-2023 / хөтөлбөртэй уялдсан болно.

Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн чиглэл бүрээр тодорхой тусгалаа.

График 11. Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний үндсэн чиг хандага




Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөлтийг газрын болон байгалийн нөөц нөхцөлд тулгуурлан дараахь эрхзүйн баримт бичгүүдийг үндэслэн боловсруулсан. Үүнд:

- “Аймаг, Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргазүйн заавар” УБ, 2008 он
- Хэнтий аймгийн аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тайлан
- “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” УБ, 2011 он
- Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм
- Монгол улсын стандарт MNS 4652-28
- Монгол улсын стандарт MNS 4628-98 “Шатахуун түгээх станц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн техникийн ерөнхий шаардлага” УБ, 1998 он
- “Харилцаа холбооны тухай хууль”, Засгийн газрын 2001 оны 263 дугаар тогтоол
- "Авто замын тухай хууль"-ийн 12.2 зүйл

- “Ойн тухай хууль” 2012 оны 5-р сарын 17
- “Аялал жуулчлалын тухай хууль” 2000 оны 5-р сарын 5

Дарви сумын нутаг дэвсгэрийн нэгдсэн төлөвлөгөөг дараах зургаар харууллаа. Газар ашиглалтын төрөл бүр дээр төлөвлөгөө гаргалаа.



Зураг 21. Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний зураг

## 4.2 Хамгаалалтын бүсийн төлөвлөгөө

Дарви сумын газар нутагт гадаргын усны хамгаалалтын бүсүүд, ойн хамгаалалтын бүс, зам шугам сүлжээний хамгаалалтын бүсүүдийг тогтоож зохих газрын хэмжээг тогтооход нийт 22990.79 га буюу 4.15%-ийг хамарч байна. Нийт хамгаалалтын бүсийн 1.48 %-ийг шугам сүлжээний газар хамгаалалтын бүс, 92.5%-ийг усны хамгаалалтын бүс, 6%-ийг ойн хамгаалалтын бүс тус тус эзэлж байна.

Гадаргын ус, худаг, шатахуун түгээх станц, өндөр хүчдлийн шугам, авто замуудад дараах төрлийн хамгаалалтын бүсүүдийг төлөвлөсөн.

Хүснэгт 32. Сумын хамгаалалтын бүсүүдийн төлөвлөгөө

№	Барилга байгууламжийн төрөл	Хамгаалалтын бүсийн төрөл	Эрхзүйн баримт бичиг	Хамгаалалтын бүсийн өргөн, м
1	Голууд	Хориглох бүс	Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм	25
2	Голууд	Хязгаарлах бүс	Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм	50
3	Нуурууд	Хориглох бүс	Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм	25
4	Нуурууд	Хязгаарлах бүс	Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм	50
5	Худаг	Хамгаалалтын бүс	Монгол улсын стандарт MNS 4652-28	50
6	Шатахуун түгээх станц	Хамгаалалтын бүс	Монгол улсын стандарт MNS 4628-98	50
7	Өндөр хүчдэлийн шугам	Хамгаалалтын бүс	"Харилцаа холбооны тухай хууль", Засгийн газрын 2001 оны 263 дугаар тогтоол	10
8	Улсын чанартай авто зам	Зурвас газар	"Авто замын тухай хууль"-ийн 12.2 зүйл	100
9	Орон нутгийн чанартай авто зам	Зурвас газар	"Авто замын тухай хууль"-ийн 12.2 зүйл	60

### 4.2.1 Усны хамгаалалтын бүс

“Монгол улсын жижиг гол, усны хамгаалалтын бүсийн дүрэм”-д зааснаар гадаргын усны нөөцийг бохирдох хомсдохоос хамгаалах зорилгоор хориглох болон хязгаарлах бүсүүд тогтоох бөгөөд дараахь зориулалтаар газар ашиглахыг хориглоно.

Хориглох бүсэд дараахь зориулалтаар газар ашиглахыг хориглоно. Үүнд:

- Гол нуур цөөрөм, булгийн усыг хомсдуулж, ширгээх болон чанарыг нь муутган өөрчлөх нөлөөлөлтэй үйлдвэр, барилга байгууламж /цэвэрлэх байгууламж, нефть бааз, цахилгаан станц/ барьж ашиглах (энэ заалтанд зөвхөн ус хангамжийн төвлөрсөн системийн барилга байгууламжийг үл хамааруулна).



- Химийн хорт бодис, төрөл бүрийн бордоо, цацраг идэвхт бодис болон түүнийг агуулсан ашигт малтмал хадгалах, агуулах, халдварт өвчин тарааж болзошгүй барилга байгууламж байрлуулах
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газрыг ашиглах
- Барилгын карьер гаргах
- Гахай шувууны байр, саалийн механикжсан ферм, мал угаах цэг байршуулах.
- Автомашины шатахуун түгээх газар байгуулах, машин техник угаах, засварлах, бохир усны нүх, бие засах газар барих.
- Байгаль хамгаалах зохих арга хэмжээг авахгүйгээр амралт сувилалын газар байгуулах.

Хязгаарлах бүсэд дараахь зориулалтаар газар ашиглахыг хориглоно. Үүнд:

- Гол нуур цөөрөм, булгийн усыг хомсдуулж, ширгээх болон чанарыг нь муутган өөрчлөх нөлөөлөлтэй үйлдвэр, барилга байгууламж /цэвэрлэх байгууламж, нефть бааз, цахилгаан станц/ барьж ашиглах (энэ заалтанд зөвхөн ус хангамжийн төвлөрсөн системийн барилга байгууламжийг үл хамааруулна).
- Химийн хорт бодис, төрөл бүрийн бордоо, цацраг идэвхт бодис болон түүнийг агуулсан ашигт малтмал хадгалах, агуулах, халдварт өвчин тарааж болзошгүй барилга байгууламж байрлуулах.
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газрыг ашиглах.
- Автомашины шатахуун түгээх газар байгуулах.

Шатахуун түгээх станцын хамгаалалтын бүсэд дараахь зориулалтаар газар ашиглахыг хориглоно. Үүнд:

- Орон сууц, нийтийн үйлчилгээний газар
- Хүнсний үйлдвэрлэлийн объект
- Гэр хороолол
- Албан газрын барилга байгууламж.

*Хүснэгт 33. Усны хамгаалалтын бүсүүдийн талбай*

Д/д	Хамгаалалтын бүс	Хамгаалалтын бүсийн өргөн	Талбай, га
1	Булгийн онцгой хамгаалалтын бүс	50 м	33.66
2	Булгийн энгийн хамгаалалтын бүс	200 м	391.93
3	Нуурын онцгой хамгаалалтын бүс	100 м	223.56
4	Нуурын энгийн хамгаалалтын бүс	200 м	193.32
5	Худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс	50 м	72.25
6	Худгийн эрүүл ахуйн хязгаарлалтын бүс	200 м	1064.46
7	Голын онцгой хамгаалалтын бүс	100 м	10320.36
8	Голын энгийн хамгаалалтын бүс	200 м	8978.22
<i>Нийт</i>			21277.75

#### 4.2.2 Ойн хамгаалалтын бүс

Дарви сумын хэмжээнд нийт 1370.9 га газар ойн модоор бүрхэгдсэн газар байна. Сумын ойн газар нь Сутай уулын салбар уулс болох Мандалын хөндий, Цэцэрлэгийн нуруу, Өлзийтийн нуруугаар байна. Эдгээр модоор бүрхэгдсэн газрын ой нь бүгд хамгаалалтын бүсийн ой буюу 100 га хүртэлх ойд хамаарагдаж байна.

Ойн ашиглалт, хамгаалалтад дараах шаардлага нөхцөлийг хангаж ажиллах шаардлагатай.

- Газрын нэгдмэл сангийн тооллогын аргачилсан зааврын дагуу сумын ойн сан бүхий газарт ойн захаас гадагш 100 м зурвас газар нь ой тэлэн ургах нөөц газарт бүртгэгддэг тул уг газарт бэлчээрээс бусад зориулалтаар газар ашиглахыг хориглоно.
- Хөрсийг усны эвдрэлээс хамгаалах, газрын доорхи болон гадаргуугийн усны тэнцлийг хадгалах зорилгоор гол горхины эх, нуурын эргэн тойронд 5 км-ээс дотогш, голын эргээс хоёр тийш урсгалын дагуу, булаг шандын тархины эргэн тойрны 3 км доторхи газарт хориотой бүсийн ойн хилийг татдаг бөгөөд тус сумын хувьд тус бүс нь хамгаалалтын бүсэд багтаж байгаа юм.
- Ойн нөхөн төлжилтийг хангах ойн захаас 100 метр хүртэлх зай болон ойн цоорхойд даацаас хэтэрсэн мал бэлчээх, сэлгээгүй хадлан бэлтгэх зэргээр ой мод байгалийн жамаар үрээ хаяж, нөхөн төлжих боломжийг алдагдуулахгүй байх, ашиглалтын явцад зохистой хэмжээний төлбөр ногдуулах арга хэмжээ авбал зохино.
- Ойн хөнөөлт шавьж хүр эрвээхэйн өндөг ихээр тархсан газруудад устгал хийх, ойгоос их хэмжээгээр мод огтлохгүй байх зэрэг нийтлэг арга хэмжээ авахаас гадна ойн ашиглалт болон хамгаалалтын бүсүүдэд ашиглалтын горимыг мөрдөнө.

*Хүснэгт 34. Ойн хамгаалалтын бүсийн талбай*

Д/д	Хамгаалалтын бүс	Хамгаалалтын бүсийн өргөн	Талбай, га
1	Хамгаалалтын бүсийн ой	100 га хүртлэх хэмжээний ой	1370.90

#### 4.2.3 Зам шугам сүлжээний хамгаалалтын бүс

“Харилцаа, холбооны тухай хууль”-д зааснаар холбооны сүлжээнд зориулан олгосон хамгаалалтын зурвас газрын өргөн нь агаарын баганат шугамын хувьд 20 метр, кабелийн шугамын хувьд 10 метр байна. Холбооны мэдээлэл хүлээн авах станцын талбайн хэмжээг радио релейн шугамын станц хоорондын буюу сансрын холбооны хиймэл дагуулын газрын

нэвтрүүлэх станцын долгион цацалтын орон зай, тухайн станцаас тал бүртээ 300 метрийн голчтойгоор, радио, телевизийн нэвтрүүлэх станцын болон долгион үүсгэх тоног төхөөрөмжийн хүчин чадлаас хамааруулан тогтоосон эрүүл ахуйн бүсээр авна.


Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын бүсийг Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 263 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасны дагуу авна.

Хамгаалалтын зурваст ажил, үйлчилгээ явуулах

- Хамгаалалтын зурваст инженерийн шугам сүлжээ барьж байгуулах, авто замын гарц гаргах, газар шорооны ажил гүйцэтгэхдээ эрчим хүчний шугам сүлжээний ашиглалтын байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.
- Хамгаалалтын зурваст эрчим хүчний шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн горим, ажиллагааг алдагдуулахаар үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглоно.
- Дулааны шугамд тусгай зориулалтын автомашин, механизмаар ажил, үйлчилгээ явуулах шаардлагын үүднээс түүний дээгүүр өнгөрөх цахилгаан болон холбооны агаарын шугамыг 10 м-ээс доошгүй өндөрт татсан байна.
- Эрчим хүчний шугам сүлжээг шилжүүлэх, түүнд өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага гарвал холбогдох зардлыг хүсэлт тавьсан байгууллага хариуцаж, шугам сүлжээний ашиглалт хариуцсан байгууллагын зөвшөөрлөөр түүний хяналтын дор гүйцэтгэнэ.
- Хамгаалалтын зурвас дотор газар дор байрласан инженерийн шугам сүлжээг ашиглагч байгууллага нь уг шугамын байршлын зураглалыг эрчим хүчний хангагч байгууллагад өгсөн байвал зохино.
- Хамгаалалтын зурваст газар шорооны ажил гүйцэтгэсний дараа хамгаалалтын зурвасын талбайг хэвийн байдалд нь оруулан сэргээнэ.

*Хүснэгт 35. Шугам сүлжээний хамгаалалтын бүсийн талбай*

Д/д	Хамгаалалтын бүс	Хамгаалалтын бүсийн өргөн	Талбай, га
1	Холбооны шугамын хамгаалалтын зурвас	10 м	101.78
2	Эрчим хүчний шугамын хамгаалалтын зурвас	10 м	240.35



Зураг 22. Хамгаалалтын бүсүүдийн төлөвлөгөөний зураг.

### 4.3 Хөдөө аж ахуйн газрын төлөвлөгөө

#### 4.3.1 Бэлчээрийн газрын төлөвлөгөө

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тухайн нутгийн онцлог, бэлчээрийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг харгалзан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны нутгуудад хуваарилан Багийн ИНХ-аар хэлэлцүүлж цаашид ИТХ батлуулж ажиллах боломжтой тул бэлчээрийн газрыг хуваарилан төлөвлөгөөнд тусгалаа.

Бэлчээрийн газарт нөлөөлөх хүчин зүйлүүдэд газарзүйн байрлал, газрын гадаргын хэв шинж, байгаль цаг уурын онцлогтой уялдуулан бэлчээрийн улирлын ашиглалтын байршлыг тогтоож зураглалаа. Бэлчээрийн улирлын ашиглалтыг дараах төрлүүдэд хуваана. Үүнд:

1. Өвлийн бэлчээр–өвлийн улирал нь агаарын температур хамгийн хүйтэн, бэлчээрийн ургамлын шим муудаж, хагдарч унасан, цасанд дарагдсан, ил задгай усгүй болсон хамгийн ширүүн улирал юм. Иймд өвлийн бэлчээрээр салхи багатай нөмөр нөөлөгтэй, нимгэн цас унадаг, үетэн ургамал зонхилсон, уул толгодын өвөр энгэр ээвэр болон дэрс буттай хотгор газрыг сонгоно.
2. Хаврын бэлчээр–Агаарын температур нэмэх градуст шилжиж дулаарах боловч огцом хүйтрэх, хүчтэй шуурга тавих зэрэг эрс тэс нөхцөл байнга тохиолдож мал төллөж эхэлддэг. Иймд малчид гарсан төлийг бойжуулахад онцгой анхаардаг учраас хаврын улирлын бэлчээр нь малыг салхинаас нөмөрлөсөн, цас түрүүлж хайлдаг энгэр ээвэр, чийг сайтай, зөөлөн хөрстэй бууцнаасаа холгүй газрыг сонгоно.
3. Өвөл хаврын бэлчээр–Өвөл хаврын улиралд дараалан нутаглах боломжтой өвөл хаврын бэлчээрийн төрх, нөхцлийг хангасан газрыг сонгоно.
4. Зун намрын бэлчээр–Зун намрын улиралд дараалан нутаглах боломжтой зун намрын бэлчээрийн бэлчээрийн төрх, нөхцөлийг хангасан газрыг сонгоно.
5. 4 улирал буюу эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бэлчээр–Сүүлийн жилүүдэд төв суурин газарлуу шилжих хөдөлгөөн нэмэгдэж бэлчээрийн сэлгээ хийх нөөц хомсдсон, нөгөөтэйгүүр малчид маань нэг газраа төвхинөж цөөн тооны ашиг шим өндөртэй малтай өрх нэмэгдсэн зэрэг шалтгаанаас болж нэг доороо жил тойрон нутаглах болсон. Иймд 4 улиралд ашиглах боломжтой нөхцөл бүрдсэн газрын сонгоно.
6. Бусад–алслагдсан болон худаг уст цэг байхгүйн улмаас ашиглагдахгүй байгаа бэлчээр .


Дарви сумын хувьд бэлчээрийн газар нь 7 хэв шинжийн улирлын хэсгээр бэлчээрийг ашиглаж байгаа бөгөөд сумын нийт бэлчээрийн 22.2% буюу 122273.8 га бэлчээрийг өвлийн улиралд, 21.7% буюу 119430.26 га бэлчээрийг хаврын улиралд, 7.7% буюу 42559.18 га бэлчээрийг өвөл-хаврын улиралд, 7.4% буюу 40806.4 га бэлчээрийг зуны улиралд, 23.66% буюу 130318.1 га бэлчээрийг намрын улиралд, 17.3 хувь буюу 95434.3 га талбайг гурван улиралд, 0.36% буюу 2028.2 га талбайг дөрвөн улиралд тус тус ашигладагыг хээрийн хэмжилт судалгаа, тохиромжтой байдлын үнэлгээ, одоогийн ашиглалтын байдал, санал асуулга, хэлэлцүүлэг зэрэг олон хүчин зүйлийн хамаарлаас судлан тогтоолоо.


Хүснэгт 36. Сумын улирлын бэлчээр ашиглалт, багаар

Д/д	Бэлчээрийн төрөл	Булаг баг	Дэлгэр баг	Мөрөн баг	Мөнгөн-Аяга баг	Булган баг
1	Өвөл	25856.9	29454.0	41409.3	25553.6	
2	Хавар	30654.2	59014.2	8717.1	21044.8	
3	Өвөл, хавар			42559.2		
4	Зун	12621.6		24072.9	4111.9	
5	Намар	10060.4	48792.5	40133.8	31331.4	
6	Намар, өвөл, хавар	30036.4	14934.2		50463.7	
7	Дөрвөн улирал					2028.2
<i>Нийт</i>		<i>109229.5</i>	<i>152194.9</i>	<i>156892.3</i>	<i>132505.4</i>	<i>2028.2</i>

Дарви сумд тодорхойлсон бэлчээрийн улирлын ашиглалтуудын багтаамжийг сумын хэмжээгээр авч үзэхэд өвөл, хаврын бэлчээрийн даац багтаамж харьцангуй сайн, зуны бэлчээрийн даац багтаамж бага байна. Өвлийн бэлчээр, зуны бэлчээр Мөрөн багт ойролцоо нутагт байрладаг учраас бэлчээрийн даац 10-20 дахин хэтэрсэн маш их ашиглалттай байна. Иймд өвөл болон зуны бэлчээрийг ялган, улирлын бэлчээрийг хугацаандаа ашиглах, мөн хаваржаа, өвөлжөөний нутагт малчин өрхүүдийг бага нэмэх хэрэгтэй.

График 12. Улирлын бэлчээрийн эзлэх хувь





Зураг 23. Улирлын бэлчээр ашиглалтын зураг.


### 4.3.2 Бэлчээр усжуулалтын төлөвлөгөө

Гадаргын усны судалгааг гаргасны үндсэн дээр Дарви сумын хэмжээнд усжуулагдсан нутаг 4446847.3 га буюу 80.3 хувь нь бөгөөд харин усжуулах шаардлагатай нутаг бэлчээр 107670.4 га буюу 19.4 хувь байна. Усжуулах шаардлагатай бэлчээрийн 24.6% буюу 27082.9 га бэлчээр нь Булаг багт, 19.3 хувь буюу 29324.5 га бэлчээр нь Дэлгэр багт, 10.98 хувь буюу 17469 га бэлчээр Мөрөн багт баг, 25.65 хувь буюу 33794 га бэлчээр Мөнгөн-Аяга багт тус тус байна. Булаг багийн Талын толгой, Хүйсийн говь орчмын бэлчээр, Дэлгэр багийн Баруун тал, Хатуугийн гол, Дөрвөн толгой талын бэлчээрүүд, Мөрөн багийн Буйсийн гозгор, Дөрвөн толгойн тал, Мөрөнгийн тал орчмын нутаг, Мөнгөн-Аяга багийн Таван хайрханы тал, Тунгалагийн тал, Хойд ширээ орчим бэлчээрүүдийг усжуулах шаардалагтай байна.


Хүснэгт 37. Бэлчээр усжуулалтын судалгаа

Бэлчээр	Баг	Талбай, га
Усжуулагдсан бэлчээр	Баянбулаг	82928.31
	Дэлгэр	122814.37
	Мөрөн	141145.42
	Мөнгөн-Аяга	97931.12
	Булган	2028.08
<b>Нийт - 80.58</b>		<b>446847.30</b>
Усжуулах шаардлагатай бэлчээр	Булаг	27082.90
	Дэлгэр	29324.5
	Мөрөн	17469
	Мөнгөн-Аяга	33794
<b>Нийт - 19.42</b>		<b>107670.40</b>

График 13. Бэлчээр усжуулалтын хувь








Зураг 24. Усжуулах шаардлагатай бэлчээрийн төлөвлөгөөний зураг

Иргэдийн санал болон багийн Иргэдийн нийтийн хурлаас гарсан саналыг хөв цөөрөм байгуулах газрын тохиромжтой байдлын үнэлгээнд үндэслэн хөв, цөөрөм байгуулах газрын байршлыг төлөвлөгөөнд тусгаж өглөө.

Хүснэгт 38. Хөв, цөөрөм байгуулах газрын төлөвлөгөө

Д/д	Газрын нэр	Х	Ү
1	Бумбатайн булаг	47° 8' 25.240" N	93° 20' 26.870" E
2	Тахилтын булаг	47° 13' 6.290" N	93° 18' 37.990" E
3	Хөшөөтийн гол	46° 57' 25.784" N	93° 15' 51.936" E



Зураг 25. Хөв, цөөрөм байгуулах газрын төлөвлөгөөний зураг

**4.3.3 Бэлчээрийн ашиглалтын хэсгийн төлөвлөгөө**

Бэлчээрийн газар ашиглалт нь сумын үндсэн газар ашиглалт бөгөөд цаашид бэлчээрийг өнө удаан хугацаанд тогтвортой ашиглахын тулд улирлын сэлгээг сайн хийх, бэлчээрийн даац багтаамжид тааруулж малаа өсгөх, хамгаалах, тордох, эзэнтэй болгох, нөхөн сэргээдэг байх шаардлагатай. Иймд бид энэхүү нутаг дэвсгэрийн төлөвлөгөөнд бэлчээр ашиглалтын хэсэг гэсэн бэлчээр ашиглалтын хэлбэрийг тогтоож төлөвлөгөөнд тусгалаа. Энэхүү бэлчээр ашиглалтын хэсгийг малчдын саналын үндсэн дээр тогтоосон ба Багийн Иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлж тогтоосон болно. Дарви сумын хэмжээнд бэлчээр ашиглалтын 166 хэсгийг тогтоож энэхүү төлөвлөгөөнд тусгасан ба хэсэг бүрт багтах малчдын байршлын тоог доорх хүснэгт харуулав.


Хүснэгт 39. Бэлчээр ашиглалтын хэсгийн талбай

Багийн нэр	Бэлчээр ашиглалтын хэсгийн дугаар	Талбай, га	Нийт малын тоо	Өвөлжөө	Хаваржаа	Өвөлжөө, Хаваржаа	Зуслан	Намаржаа	3 улирал
Булаг баг	2, Харганы тал	2529.4	4518	6					
	3, Хонгор толгой	948.5	7685	9					
	4, Холбоо толгой	678.2	4848	4					
	5, Чулуутын ам	1084.0	727	1					
	6, Сэнжит цахир толгой	3222.1	4329	8					
	7, Мөстийн хөндий	3771.3	8382	8					
	8, Хавчигийн хөндий	1650.2	4585	5					
	9, Бор уул	4165.1	4321	4					
	10, Гэр чулуу	577.7	877	3					
	11, Их хүүш	1355.4	3965	6					
	12, Их дулаан	1387.9	2646	4					
	13, Тосонгийн ам	2044.9	3412	6					
	14, Хавчгийн сайр	3877.8	5488		5				
	15, Булагын адаг худаг	7464.3	3722		5				
	17, Морин толгой	1360.9	1839		1				
	18, Талын толгой	1124.8	5925		5				
	19, Ург тал	3434.3	1762		2				
	20, Хүнхэр	1369.5	4302		3				
	21, Боодог толгой	1513.1	2053		2				
	22, Боодог	820.5	2615		2				
	23, Цахирын худаг	1477.6	2674		3				
	24, Улаан толгой	2077.7	5255		6				
	25, Сүүжийн худаг	3222.3	5299		7				
	26, Боомын уул	6568.7	0					1	
	27, Сүүл харын худаг	6052.9	655					1	
	28, Буянт овоот	5430.6	4192						4
	29, Хүйсийн говь	2131.9	1363						1

Дэлгэр баг	32, Нурамт	4108.5	5857	5					
	33, Шарил овоо	1188.1	4249	6					
	34, Мандалтын хөндий	1400.0	7693	10					
	35, Алаг дэлгэр	693.9	1540	3					
	36, Цэцэрлэгийн гол	892.7	3882	4					
	37, Урд өлзийт	1994.4	3985	6					
	38, Агуйт цахир	1753.5	2105	2					
	39, Баян-Өндөр	1283.9	846	2					
	40, Ар хүүш	4328.8	818	1					
	41, Улаантолгой	2872.2	585	1					
	42, Баян-Өндөрийн өвөр	4214.1	7342	6					
	44, Хөх энгэр	3781.6	4383	3					
	45, Бага Алтангадас	5385.5	6732		6				
	46, Баянцагааны овоот	2742.6	2680		3				
	47, Хоёр худаг уул	8137.4	5031		4				
	48, Овоот уул	2164.0	1264		1				
	49, Ил уул	2633.9	2254		3				
	50, Хонгилт уул	1505.9	2480		2				
	51, Алаг уулын гозгор	1770.3	2806		3				
	52, Хүүш	3863.7	2905		4				
	53, Ташгайн цахир	1368.4	93		1				
	54, Халтарын худаг	3184.6	4213		8				
	55, Булган овоо	1912.0	1670		3				
	56, Цахир толгой	4087.1	3940		6				
	57, Халтар уул	2600.9	2109		3				
	58, Цагаан дэрстэй	1914.6	794		1				
	59, Хар үзүүр	2188.1	1354		2				
	60, Ягаан дэл	6775.9	2503		6				
	61, Улаан хоолой	3184.6	3522		3				
	62, Ембүү овоо	3594.7	2355		3				
	63, Бяцхан дашгай	6216.2	299						1
	65, Бургастайн хөндий	12451.2	1005						2
	67, Дэлгэрийн ам	1553.4	2828						1
	68, Наран булаг	1446.0	1680						1
	70, Цэцэрлэгийн нуруу	3571.7	411						1
	71, Дөрвөн толгой	6103.4	0						1
72, Цахиуртай худаг	5941.1	0						1	
73, Дэлгэрийн хөл	5218.8	6004						5	
74, Баруун тал	2543.1	1674						2	
75, Хүнхэрийн сайр	2506.6	1306						1	
76, Олон хунх	4665.7	0						1	
Мөрөн баг	77, Мөрөн хөмс	1713.2	2082	3					
	78, Хөндлөн хөндий	1554.1	956	1					
	79, Баян толгойн худаг	1212.3	1400	1					
	80, Дөт	1908.1	6156	5					
	81, Бөөрийн нуруу	2259.5	6710	7					

	82, Дэнгийн худаг	4731.8	7352	9					
	83, Хадан	6709.6	2939	5					
	84, Цагаан даваа	4659.0	6381	10					
	85, Их наран	3594.6	1817	2					
	87, Мозонгийн сайр	1312.6	244	1					
	88, Нарангийн нуруу	1924.0	2456	2					
	89, Эмээл хадан цохио	1707.3	1224	3					
	90, Яргайт	2206.4	312	1					
	93, Гурван амт	1663.9	4361	4					
	94, Цагаан ганга	3205.3	513		1				
	95, Хар хадат толгой	1382.1	6926		6				
	96, Хүрэн толгой	743.4	542		2				
	97, Хойт жант	1390.4	1207		1				
	98, Талын товгор	1995.9	1001		1				
	99, Баруун ханан	11698.6	5560			6			
	100, Ганц амт	4372.2	1579			2			
	101, Баастын хоолой	4871.2	3788			4			
	102, Хар чулуут	6654.8	1298			1			
	103, Хүрэн өндөр	4800.1	535			1			
	104, Алаг дором	2365.3	1104			2			
	105, Хавчиг	4624.9	1408			1			
	106, Их ташгай	3172.1	2439			3			
	107, Буурал богд	13866.6	0				2		
	108, Жинст	5843.8	2716				3		
	109, Мөнгөт уул	1624.4	749				2		
	110, Дайчин	2738.1	980				1		
	111, Цагаан нуур	5005.9	4344					3	
	112, Дөрвөн толгой тал	3122.9	0					1	
	113, Мөрөнгийн тал	7885.3	1709					3	
	114, Шанаа	3580.8	529					1	
	115, Хөдөө булаг	3369.3	5705					5	
	116	4801.3	524					3	
	117, Цагаан нуурын зүүн дэрс	1505.3	1040					3	
	118, Бор харганы тал	3947.2	2775					6	
	119, Зэгстэй булан	1043.2	1626					1	
Мөнгөн-Аяга баг	122, Сайр	847.4	1498	2					
	123, Булагийн адаг	781.2	329	1					
	124, Захын овоот толгой	402.0	671	1					
	125, Шар булагийн нуруу	1615.7	2459	3					
	126, Цагаан сайрын хөндий	3388.5	629	1					
	127, Бор нуруу	1602.1	3043	4					
	128, Хүүш	603.7	527	1					
	129, Цагаан шороо	932.6	1586	2					
	130, Уртын адаг	1047.9	2026	2					
	131, Шил	871.3	1838	3					
	132, Хар толгой	676.3	1219	2					

	133, Мөнгөн-Аяга	853.1	1613	3					
	134, Зураачийн худаг	871.8	2141	3					
	135, Цахир толгой	711.4	4067	5					
	136, Шовгор дулаан	573.2	302	1					
	137, Талын худагийн тал	654.6	3485	4					
	138, Ац толгой	855.4	4115	5					
	139, Ганц толгой	379.5	1282	2					
	140, Мөстийн хойд нуруу	1250.9	5680	6					
	141, Өндөр хар	1904.5	2596	3					
	142, Хар уул	1061.0	3523	4					
	143, Хэрэлт	739.0	3269	3					
	145, Гурван толгой	3136.8	2495		4				
	146, Дэчингийн уул	1692.2	6829		5				
	147, Ухараа уул	2236.5	3623		3				
	148, Хонгор толгой	5085.0	3788		5				
	149, Улаан толгой	1811.9	3207		4				
	150, Тогоот	1047.1	1062		1				
	151, Дэн	1538.3	2738		3				
	152, Нөмөр толгой	2003.8	1126		2				
	153, Хараатын худаг	2493.2	3363		3				
	154, Чулуутын нуруу	3402.9	3392				5		
	155, Шар булаг	709.0	1235				1		
	156, Хотгорын тал	31331.4	0					1	
	157, Улаан толгой	6883.0	2749						5
	158, Зэгстэйн тал	9660.4	1218						3
	159, Гашууны худаг	2256.9	2146						3
	160, Оцон	1678.2	2179						4
	161, Цагаан толгойн худаг	8565.5	3369						4
	162, Гунгалагийн тал	10002.0	3596						3
	163, Талын толгой	1911.9	1022						1
	164, Бага Навтгар	6429.6	2339						3
Булган баг	165, Төр мөнхийн толгой	2028.2	2146						1



Зураг 26. Бэлчээр ашиглалтын хэсгийн төлөвлөгөө зураг

Хүснэгт 40. Бэлчээр ашиглалтын хэсгийн багтаамж

Баг	Талбай, га	Га-ийн ургац, цн	Тэжээлийн нөөц, цн	Багтаамж, хонин толгой
1. Их дулаан	2442.236	1.835	4481.503	1067.025
2. Харганы тал	2479.608	1.725	4277.324	1018.411
3. Хонгор толгой	697.510	1.760	1227.618	292.29
4. Холбоо толгой	678.213	1.300	881.68	209.923
5. Чулуутын ам	1071.493	1.935	2073.34	493.6521
6. Сэнжит цахир толгой	3172.924	1.835	5822.32	1386.266

7. Мөстийн хөндий	3771.305	1.923	7253.48	1727.018
8. Хавчигийн хөндий	1600.484	2.000	3200.97	762.1352
9. Бор уул	4123.173	1.835	7566.02	1801.434
10. Гэр чулуу	574.524	1.835	1054.25	251.0124
11. Их хүүш	1330.846	1.900	2528.61	602.0496
12. Их дулаан	1375.308	1.900	2613.09	622.1633
13. Тосонгийн ам	2018.190	1.400	2825.47	672.7301
14. Хавчгийн сайр	3858.771	2.018	7785.07	1853.588
15. Булагын адаг худаг	7451.885	2.018	15034.18	3579.566
16. Талын толгой	2911.366	1.974	5747.04	1368.342
17. Морин толгой	1349.689	1.950	2631.89	626.6411
18. Талын толгой	1112.229	2.000	2224.46	529.6329
